

АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ

“Хүний эрх ба хүнд суртал - Нийгмийн халамжийн салбар дахь төрийн үйлчилгээ” судалгааны ажил

1.1. Судалгааны ажлын зорилго, зорилт, хамрах хүрээ

Нийгмийн халамжийн салбарт төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар санал, зөвлөмж боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажлын зорилгыг хангах үүднээс дараах үндсэн 4 зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөж хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Халамжийн салбарт үйлчилж буй эрх зүйн баримт бичгүүдэд шинжилгээ хийх замаар төрөөс үзүүлж буй халамж үйлчилгээний хүрээнд шаардлагагүй зохицуулалт, босго, шалгуур байгаа эсэхийг тодруулж, Нийгмийн халамжийн шинэ хуульд нийцүүлэн гаргах дүрэм журмуудад тусгах санал боловсруулах Зорилт 2. Сонгосон төрийн байгууллагууд дээр ажиглалтын судалгаа явуулж, үйл ажиллагааны доголдол, давхардал, шаардлагагүй шат дамжлага, ажил үүргийн оновчгүй хуваарилалт байгаа эсэхийг тодруулах, мэдээллийн ил тод байдалд шинжилгээ хийх Зорилт 3. Иргэд, төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдийн санаа бодлыг тандах, ярилцлага хийх, баримт цуглуулах, тохиолдол судлах замаар халамжийн салбар дахь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд хүндрэл бэрхшээл, хүнд суртал, чирэгдэл байгаа эсэхийг тодруулах

Зорилт 4. Төрөөс иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээнд оршиж буй хүндрэл бэрхшээл, хүнд суртал, чирэгдлийг арилгах арга замыг тодорхойлж, түүнийг сайжруулах санал бүхий зөвлөмж боловсруулах

Судалгааны хамрах хүрээ.

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам,
2. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар,
3. Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс,
4. Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх Нэг цонхны үйлчилгээний төв
5. Сүхбаатар дүүргийн ЗДТГ, тус дүүргийн 2 дугаар хороо,
6. Сонгино хайрхан дүүргийн ЗДТГ, тус дүүргийн 1 дүгээр хороо,
7. Баянзүрх дүүргийн ЗДТГ, тус дүүргийн 9 дүгээр хороо

1.2. Үндсэн үйл ажиллагаа

Нийгмийн халамжийн бодлогын холбогдох эрх зүйн баримт бичигт шинжилгээ хийж, нийгмийн халамжийн чиглэлээр иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар баримт цуглуулах, ажиглалт судалгаа хийх, иргэд, төрийн албан хаагчдаас ярилцлага авах, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна. Судалгааны зорилго, зорилтыг хангах дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 1-ийн хүрээнд:

- 1.1. Нийгмийн халамжийн чиглэлээр үйлчилж буй хууль, дүрэм журам бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд шинжилгээ хийнэ.
- 1.2. Нийгмийн халамжийн чиглэлээр гарсан Засгийн газрын хөтөлбөрүүд, сонгон авсан дүүргүүдийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, нийслэл дүүргийн хөдөлмөр, халамжийн хэлтсүүдийн үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийнэ.
- 1.3. Сонгосон байгууллагуудын дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт болон бусад холбогдох баримт бичгүүдийг судалж, бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, үйл ажиллагааны давхардал, доголдол, ажил үүргийн оновчгүй хувиарлалт байгаа эсэхийг тодруулах
- 1.4. Эрх зүйн баримт бичгийн шинжилгээ, сонгосон дүүргүүд дээр хийсэн ажиглалт, анкетын болон ярилцлагын судалгааны дүнд үндэслэн Нийгмийн халамжийн шинэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах дүрэм журмуудад тусгах санал —ёоловсруулна.

Зорилт 2-ийн хүрээнд:

2.1. Ажиглалтын судалгаагаар /хороо, дүүргийн түвшинд/ халамжийн байгууллагын үйл ажиллагаанд давхардал, шаардлагагүй шат дамжлага, ажил үүргийн оновчгүй хуваарилалт байгаа эсэхийг тодруулна.

Халамжийн үйлчилгээний төлбөр хураамж, зарцуулж буй цаг хугацаа, бүрдүүлж буй баримт бичгүүдийн төрөл зүйл, давхардал байгаа эсэхийг тодруулна.

Иргэд хамгийн олноор хамрагдаж буй халамжийн үйлчилгээний төрлийг тодруулж, 4-5 төрлийг сонгон авч уг судалгааг явуулна. Ажиглалтын нэг объект дээр 2 судлаач, ажлын 3 хоног ажиллаж мэдээллийг цуглуулна.

2.2. Мэдээллийн ил тод бус, тодорхойгүй байдлын улмаас иргэд, төрийн үйлчилгээг авах явцад цаг хугацаа алдах, үргүй зардал гаргах зэрэг нөхцөл байдал үүсч байгаа эсэхийг тодруулна.

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын мэдээллийн самбар, тараах материал, танилцуулах хуудас болон вэб сайтын мэдээллийн бүтцэд агуулгын шинжилгээ хийнэ. Ингэхдээ “Төрийн байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”²-ийг ашиглана.

- Зорилт 3-ийн хүрээнд хийгдэх судалгааны хүрээнд дараах асуудлуудыг тодруулна. Халамжийн үйлчилгээ иргэдэд тэгш, хүртээмжтэй байж чаддаг эсэх,

Мэдээллийг иргэд хаанаас ихэвчлэн авдаг,

Мэдээллийн самбар, тараах материал, танилцуулах хуудас болон вэб сайтын мэдээллүүд нь иргэдэд тусламж болж чаддаг эсэх Мэдээллийг байнга шинэчилдэг эсэх

Мэдээллийн тодорхойгүй байдлын улмаас үүсч буй хүндрэл чирэгдэл байгаа

эсэх Зорилт 3-ийн хүрээнд:

Халамжийн салбар дахь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд учирч буй бэрхшээл тулгамдсан асуудлаар төрийн албан хаагчид, мэргэжилтнүүд, иргэдийн санаа бодлыг тандах, баримт цуглуулах, тохиолдол судлах судалгаа хийнэ. Үүний тулд дараах судалгаануудыг тусгай удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ. Судалгаа тус бүрийн удирдамжид судалгааны хамрах хүрээ, тодруулах асуудал, арга зүйг нарийвчлан тусгана.

3.1. Анкетын судалгаа. Халамжийн үйлчилгээ авахад саад бэрхшээл, хүнд суртал, олон шат дамжлага байгаа эсэхийг тодруулах зорилгоор сонгогдсон дүүргийн иргэдээс анкетийн судалгаа авна. Сонгосон дүүргийн халамжийн үйлчилгээ авч буй иргэдээс

² Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол.

түүврийн аргаар респондентыг сонгож, нэг дүүргээс 50-аас доошгүй иргэдээс судалгаа авна.

3.2. Фокус бүлгийн ярилцлага. Сонгосон дүүргийн иргэдээс хөдөлмөр эрхэлдэггүй хүмүүс, хөгжлийн бэршээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн буюу хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд зэрэг халамжийн үйлчилгээ авч буй зорилтот бүлгийн төлөөллийг харгалзан сонгон авч хороо, дүүрэг тус бүрд 1, нийт 6 фокус бүлгийн ярилцлагыг урьдчилан бэлтгэсэн асуултаар зохион байгуулна. Ярилцлагад нийт 72 хүн /нэг бүлэгт 12/хамрагдана.

3.3. Ганцаарчилсан ярилцлага.

Экспертийн ярилцлага. Халамжийн үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагуудын ажилтан 18/, сонгосон дүүргийн хороодын зохион байгуулагч 13/, нийгмийн ажилтан 13/, халамжийн ажилтан 16/, өрхийн эмнэлгийн эмч 13/, иргэний бүтгэлийн ажилтан 13/, хэсгийн ахлагч 13/ нараас экспертийн гүнзгийрүүлсэн ярилцлага авна. Дээрх ажилтнуудыг хороо, дүүрэг тус бүрээс сонгон авч, нийт 29 хүнд экспертийн ярилцлага хийнэ.

Иргэнтэй хийх ярилцлага. Халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдээс халамжийн үйлчилгээний зорилтот бүлгийн төлөөллийг хамруулан дүүрэг тус бүрт 6, нийт 18 иргэнтэй ярилцлага хийнэ.

3.4.Тохиолдлын судалгаа /Кейс судалгаа/. Нийгмийн халамжийн салбар дахь төрийн үйлчилгээг хүртэж буй иргэдийн эрх, эрх ашгийг хөндсөн тодорхой тохиолдолд (баримт жишээ) тулгуурлан хүний эрхийн хэрэгжилтийн байдал, үзүүлж буй төрийн үйлчилгээний зэрэг болон сөрөг үр дагавар, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор Кейс судалгааг хийнэ. Нийгмийн халамжийн салбар дахь төрийн үйлчилгээний байдлыг тоон шинжилгээгээр бус нийтлэг үзэгдлийн ерөнхий хандлагыг тодорхойлох байдлаар хийнэ. Кейс судалгааны арга зүй нь бичиг баримтын судалгаа хийх, ажиглах, ярилцлага хийх зэрэг мэдээлэл цуглуулах үндсэн техникүүд дээр тулгуурлана.

3.5. Дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх Нэг цонхны үйлчилгээний мониторинг:

Зорилго:

- Сонгосон дүүргүүдийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний үйл ажиллагаанд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

Зорилтууд:

- “Нэг цонхны үйлчилгээ”-гээр үзүүлж буй үйлчилгээний нэр төрлийг тогтоох;
- Үйлчилгээний төлбөр, хураамж, шат дамжлага, бүрдүүлэх материал, үйлчилгээг авахад зарцуулж буй цаг хугацаа, хүнд суртал, чирэгдэл байгаа эсэхэд шинжилгээ хийх;
- Мэдээлийн ил тод байдал, үйлчилгээний чанарт шинжилгээ хийх
- Үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй болгох талаар санал, зөвлөмж дэвшүүлэх

Судалгааны ажлын хүрээнд хийх үндсэн ажлууд:

- “Нэг цонхны үйлчилгээ”-гээр үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл, бүрдүүлэх материал, төлбөр хураамжийн талаар баримт бичгийн судалгаа хийнэ.
- “Нэг цонхны үйлчилгээ”-ний ажилтнуудын ажил үүргээ гүйцэтгэж буй байдал, зан харьцаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл байгаа эсэх талаар ажлын байрны зураг авалт, асуулгын судалгаа явуулна.

Зорилт 4-ийн хүрээнд

- 4.1. Төслийн судалгааны ажлуудын тайланг нэгтгэн боловсруулна.
- 4.2. Төслийн судалгааны үр дүнд тулгуурлан зөвлөмж боловсруулна.
- 4.3. Хүний эрхийн үндэсний комиссын ажилтнуудыг судалгааны ажилд оролцуулж,

1.5. Судалгааны үр дүн, тайлан

- Судалгааны тайлан, зөвлөмжийг ХЭҮК-оос боловсруулсан удирдамжийн дагуу гаргаж, хүлээлгэн өгнө.
- Төслийн явц, гүйцэтгэлийн болон санхүүгийн зарцуулалтын тайланг тус тус бичгээр гаргаж, захиалагчийн заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- Нийгмийн халамжийн салбарт иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай болгох, цаашид сайжруулах санал бүхий зөвлөмж боловсруулна.
- Дүүргүүдийн ЗДТГ-ын “Нэг цонхны үйлчилгээ”-ний чанар, хүртээмжийг сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулна.
- Нэгдсэн тайланд ХЭҮК-ын ажлын хэсгээс гаргасан саналыг судалгааны ажилд тусгаж хэрэгжүүлсэн тухай тусгайлсан заалтаар тайлагнана.

Хавсралт - 2

ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЖАГСААЛТ

	Ажилтны нэрс	Хариуцан гүйцэтгэх үндсэн судалгаа	Хариуцах дүүрэг
1	Ц.Бүжидмаа/Доктор, РБ.й/ Карьер хөгжпийн хүрээлэнгийн захирал, Судалгааны багийн ахлагч	1. ФБ-ийн болон ганцаарчилсан ярилцлагын судалгаа 2. Мэдээллийн ил тод байдлын судалгаа	• Баянзүрх
2	У.Туяа /Доктор, РИ.О/ Боловсролын хүрээлэнгийн төслийн зохицуулагч	1. Баримт бичгийн судалгаа 2. Кейс судалгаа	• НХХЯ, • Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар,
3	А.Болормаа /Докторант/ КТМС-ийн багш, судлаач	1. Бүтэц чиг үүргийн судалгаа 2. Нэг цонхны үйлчилгээ	• Сүхбаатар
4	Г.Чулуунбат /Докторант/ Удирдлагын Академийн профессорын багийн гишүүн	1. Ажиглалтын судалгаа 2. Анкетын судалгаа	• Сонгинохайрхан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛ” СУДАЛГААНЫ АЖЛЫН ГРАФИК

		ХУГАЦАА												
		Ш сар	1Ү сар				Ү сар				Ү1 сар			
		26-30	2-6	9-13	16-20	23-27	30-4	7-11	14-18	21-25	28-1	4-8	11-15	18-22
НЭГ. СУДАЛГААНЫ БЭЛТГЭЛ АЖИЛ														
	1. Судалгааны гэрээ байгуулах,													
	2. Судалгаанд хамрагдах байгууллагуудын удирдлагуудтай уулзах,													
ХОЁР. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА														
	Зорилт 1	Баримт бичгийн шинжилгээ		У	У	С	С	С	С	С	С	Т	Т	
	Зорилт 2	Ажиглалтын судалгаа		У	С	С	Т	Т						
		Мэдээллийн ил тод байдлын шинжилгээ		У	С	С	Т	Т						
	Зорилт 3	Анкетийн судалгаа		У		У	С	Т	Т					
		ФБ ярилцлага		У				С	С	Т	Т			
		Ганцаарчилсан ярилцлага		У				С	С	Т	Т			
		Кейс судалгаа		У				С	С	Т	Т			
ГУРАВ. СУДАЛГААНЫ ТАЙЛАН														
	Зорилт 4.	Тайлан, зөвлөмж боловсруулах,												
		Хүлээлгэн өгөх												
ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ХҮСЭЛТЭЭР ХИЙХ НЭМЭЛТ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ.														
		“Нэг цонхны үйлчилгээ”-д мониторинг хийх												
		Хүний эрхийн үндэсний комиссын ажилтнуудыг чадавхижуулах												

У

Удирдамж боловсруулах, бусад бэлтгэл ажил

С

Судалгааны үйл ажиллагаа,

Тайлан, дүгнэлт, багийн хэлэлцүүлэг

**ДОРНОГОВЬ, ГОВЬСҮМБЭР АЙМГУУДАД
ХИЙСЭН “ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАЛ
ЧИРЭГДЭЛ” АЖИГЛАЛТ, ТАНДАЛТЫН**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд болон хуулиар баталгаажуулсан эрхээ эдлэхэд ямар хүндрэл чирэгдэл учирч буйг тодорхойлох зорилгоор “Хүний эрх ба хүнд суртал, чирэгдэл” шалгалт, судалгааны ажлын зохион байгуулж байгаа билээ. Үүний хүрээнд 3-р сарын 26-29 ны өдрүүдэд Говьсүмбэр, Дорноговь аймгуудад зохион байгуулсан Хүний эрхийн нээлтэй өдөр арга хэмжээний үер дээрх судалгааны ажлын ажиглалт, тандалтыг хийсэн болно.

Төлөвлөгөөний дагуу Чойр, Сайншанд хотуудын Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсүүдэд 10-13 цаг хүртэл ажиллалаа.

2012 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Чойр хот

Нэг. Ажлын байрны нөхцөл байдал

Тус хотын хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс нь 5 давхар саарал орон сууцны байрны нэг давхарт байрладаг юм байна. Үүдээр нь ороход иргэдэд зориулсан хөдөлмөр, халамж үйлчилгээний мэдээлэл бүхий самбар, тараах хуудсуудыг хангалттай байрлуулж, хэлтсийн ажилтнуудын танилцуулга, холбоо барих утас, ажлын байрны тодорхойлолт зэргийг тавьжээ. Ажилтнуудын хувьд 7 хүртэл дугаарласан өрөөнд хуваагдан суух бөгөөд энэ нь иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй санагдлаа. Мөн үйлчилгээний ажилтан нь цэвэрлэгээ сайн хийдэг нь үүдээр ороход цэвэрхэн байгаагаас харагдаж байв.

Хоёр. Ажиглалт, тандалт

Энэ өдөр тус хэлтэст иргэдийн хөл хөдөлгөөн бага байгаа болов уу гэмээр санагдаж байв. Учир нь хүлээлгийн сандал дээр хүлээсэн, үүдний гадаа дугаарласан хүмүүс ер харагдахгүй, ганц хоёроороо орж гаран чимээгүйхэн үйлчлүүлж байв. Эхлээд Халамж хариуцсан мэргэжилтэн гэсэн өрөөнд орлоо. Өрөөнд мөн л халамжийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийн самбар өлгөөтэй байв. Энэ өрөөнд Ш.Түмэндэмбэрэл, М. Үржинханд гэсэн 2 мэргэжилтэн суудаг бөгөөд нэг нь заримдаа Нэг цонхны үйлчилгээн дээрээ суудаг гэж байлаа. Намайг очиход тэд хамт байж таарсан учир иргэдийг хүлээлгэж, бухимдуулах асуудал гарсангүй.

Иргэд ихэвчлэн:

Халамжийн сангаас жирэмсэн болон амаржсан эхэд олгодог тэтгэмжийн дэвтэр нээлгэх, материал бүрдүүлэлт асуух, (5хүн)

Дээрх тэтгэмжийн нэмэгдэл орсон эсэхийг лавлах, (2 хүн)

Иргэдэд олгохоор амласан нэг сая төгрөгийг хэзээ олгох талаар сураглах, (2хүн)

Алдарт эхийн одонгийн материал бүрдүүлэлт, хэзээ санхүүжилт орох зэрэг асуудлаар хандаж байв. Халамжийн нэмэгдэл болон иргэдэд олгохоор амласан 1 сая төгрөгийн тухайд одоохондоо тэр талаар мэдээлэл, санхүүжилт орж ирээгүй байна

орохоор нь зарлана гэсээр гаргаж байв Нэг хүнд ойролцоогоор 5-10 минутын хугацаанд үйлчилж байв Нэг цаг хэртэй тус өрөөнд ажиглаж зогсоход 10 иргэн үйлчлүүлээ.

Халамжийн мэргэжилтэн Ш.Түмэндэмбэрэл: Манай өрөөгөөр өдөрт дор хаяж 20- иос дээш хүн үйлчлүүлдэг. Бид 2 хоёулаа байгаа нөхцөлд ачаалал харьцангуй гайгүй байдаг. Ер нь манайх бужигнаад байх нь гайгүй.Сая бид алдарт эхийн одонгийн материалаа авсан. Бараг сарын өмнөөс мэдээллээ тарааж, зарласан боловч манайхан дандаа цагийг нь тулгаж шавдаг. Тэрнээс болж иргэд нэлээн бухимдсан. Ялангуяа нотариатын асуудал дээр. Манайх өөрийн гэсэн нотариатгүй. Гаднаас хүн ирж суудаг. Ажпын 4 өдөр ажиллаад явдаг. Цаг нь тулахаар энэ нь иргэдэд бүрэн хүрч чаддаггүй гэж хэлж байсан юм. Халамжийн мөнгө дуусчихна гэсэн ойлголттой байдаг нь бас л 2,3 хоног бужигнахад хүргэдэг ажээ.

Иргэдийн хамгийн их хандаж, ачаалал үүсгэдэг асуудал бол Хүний хөгжил сангаас олгож буй эх орны хувь хишиг байдаг. Энэ хэлтсийн хувьд Хүний хөгжил сангаас олгож буй хувь хишгийг хариуцсан мэргэжилтэн гэж тусдаа байдаг нь ажил үүргийн ачааллыг тэнцвэржүүлж, иргэдэд ч үйлчлүүлэхэд амар байв. 20 минут хэртэй ажиглалт хийхэд тус хэсгээр 4 хүн үйлчлүүлсэн бөгөөд шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хувь хишгийн асуудлаа шийдүүлэх гэсэн хүмүүс хандаж байв.

Тухайн өдөр иргэд хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтний өрөөгөөр их үйлчлүүлж байсан учир тус өрөөгөөр орлоо. Энэ өрөөнд хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн С. Оюунжаргал, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг хариуцсан мэргэжилтэн Батсүх нар суудаг юм байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн материалыг хүлээн авч байгаа учир хүн ихтэй байгаа ажээ. Гэвч зар гараад удаагүй учраас хүмүүс материалаа өгөхөөс илүүтэй материал бүрдүүлэлтийг лавлаж, зөвлөгөө авч байв. Энэхүү төсөл өмнө нь хэрэгжиж байсан учир иргэд харьцангуй мэдээлэл сайтай, мэргэжилтэн ч туршлагатай болсон нь иргэдэд өгч буй зөвлөгөөнөөс харагдаж байв. Мэргэжилтний хувьд өөрт харьяалах иргэдээ сайн мэдэж, тэдний ахуйн байдал, ур чадварт нь таарсан зөвлөгөө өгч байгаа нь сайхан санагдаж байлаа. Энэ асуудлаар бараг 10 хүн хандлаа. Тухай бүрт нь зохих зөвлөгөөг нэг бүрчлэн өгч шаардлагатай тохиолдолд лавлаарай хэмээн өөрийн утсаа бас өгч нэг хүнд 10-15 минут зарцуулж байв. Уг төслийн хүрээнд ноднин 49,5 сая төгрөгийг иргэд авсан гэнэ. Энэ жил түүнийгээ ахиулж, хүмүүсээ илүү их хамруулах зорилготой байгаа гэнэ. Энэ нь эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгогддог учир их нарийн шалгуураар шүүгддэг тэр хэрээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч ихээхэн нэмэр болдог гэж байлаа.

Мөн өөрийн компанидаа хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаг гэх нэг хүн түүнийхээ урамшууллыг авахаар хандаж байсан. Орон тоонд нь ногдуулсны дагуу 2 хүн ажиллуулдаг ч тэд ажилдаа ирдэггүй, ажлаа сайн хийдэггүй боловч нүдээ аниад ажиллуулдаг гэнэ. Тус суманд 510 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг ч тэдний дөнгөж 100 гаран нь ажил эрхэлдэг гэнэ. Энэ нь аж ахуйн нэгж, албан байгууллагууд тэднийг ажилд авах дургүй байдагтай холбоотой ажээ. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулах аж ахуйн нэгж албан байгууллагуудыг ихээхэн дэмждэг бөгөөд тэдэнд олгох урамшууллаа энэ жил нэмсэн гэж байлаа.

Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтний хувьд мөн л хүн тасрахгүй байлаа. Ажилгүй гэдгээ 2 хүн бүртгүүлж, ажилд орох хүсэлтэйгээ илэрхийлж байв. Тэднээс нэг хувь зураг авч, мэргэжил ур чадварыг нь бүртгээд эргэн холбогдоно хэмээгээд гаргав. Ажилгүйдлийн тэтгэмжээ асууж 2 хүн хандав. Тэднийг мөнгө нь ороогүй манай нягтлангаас асуу гэсэн шалтгаанаар гаргав. Мөн Хаан банкны хүний нөөцийн ажилтан ирж, тэдний шалгуурт нийцэх хүн байгаа эсэхийг лавлаж байв. Улмаар тухайн мэргэжилтнийг өөрөө тэнцэх хүмүүсээ шүүгээд банк руу нь явуулж байхаар тохиров. Хөдөлмөрийн мэргэжилтний хэлснээр тэдний зүгээс бүртгүүлсэн иргэдтэйгээ байнга холбоотой байж, ажлын зарыг цаг тухайд нь хүргэдэг ч ирэхгүй байх тохиолдол их байдаг гэнэ. Өөрөөр хэлбэл ажил хийх төдийлөн дуртай биш тэрний оронд цагийн ажилд илүүтэй хамрагдаж, тухайн үедээ мөнгө аваад л явдаг гэнэ.

Гурав. Иргэдтэй хийсэн ярилцлага

Тус сумын 8-р байрны оршин суугч, өндөр настан Амар-равдан:

Бидний насны хөгшин хүмүүс энүүгээр үйлчлүүлэх нь бага байдаг байхаа. Би хувьдаа нөгөө 1 сая төгрөгөө л сураглаж явна. Өгч эхлээгүй л байгаа гэнэ. Хөдөлмөрийн насны хүмүүс бол байнга холбоотой байх шиг байдаг. Тэдэнд бол хэрэгтэй зүйл их байдаг байх. Ер нь гайгүй байхаа. Хааяа нэг ирэхэд хэрэгтэй зүйлээ мэдээд л гардаг.

Баянтал сумын малчин Чимэдцогзол:

Газрын асуудлаар хандаад хэрэгтэй мэдээллээ авлаа. Зүгээр сайхан үйлчилж байна.

Чойр 5-16-д оршин суугч Буянтогтох:

Хүмүүс эндээс ажилд их орж байна гэж сонсоод ажилгүй хүнийг ажилд бүртгүүлэх гэж ирлээ. Ямар ч байсан бүртгүүлсэн байхад ажилд ордог гэсэн. Хэрэгтэй мэдээллээ авч чаддаг.

Чойр 4-06-д оршин суугч Цэцэгмаа:

Би халамжийн төвөөрөө байнга үйлчлүүлдэг. Одоо 6 сартай жирэмсэн. Жирэмсний тэтгэмжээ авах гэж хөөцөлдөж байна. Урд нь бас авч байсан болохоор олон дахин явсангүй. Манай энэ халамжийнхан гайгүй ааштай хүмүүс байдаг.

Нэг. Ажлын байрны нөхцөл байдал

Тус сумын хөдөлмөр халамжийн хэлтэс нь 2 давхар цагаан байранд байрладаг юм байна. Нэг давхартаа бүх мэргэжилтнүүд нь төвлөрөн суух бөгөөд эндээс иргэд үйлчилгээгээ авах ажээ. Өрөөн дотор иргэдэд зориулсан хүлээлгийн 4 сандал байв. Иргэдэд хүргэж буй мэдээллийн тухайд үүдээр оронгуут том самбар дээр хөдөлмөр, халамжтай холбоотой цаг үеийн мэдээллүүд байна. Харин өрөөн дотор тараах материалууд байлаа. Гэвч энэ нь аймгийн төвийн хэлтэс гэхэд иргэдэд хүртээмж нь бага чамлалттай санагдаж байна. Мөн иргэдэд үйлчилж буй ажилтнуудын талаарх мэдээлэл нэрнээс нь өөрөөр байхгүй байна.

Хоёр. Ажиглалт, тандалт

Өглөө 10 цагт очиход хөл хөдөлгөөн мөн л цөөтэй байв. Эхлээд хүний хөгжил сангийн мэргэжилтэн Б. Энхжаргалтай уулзлаа. Тэднийх ер нь л овоороод байдаггүй. Хөл хөдөлгөөн гайгүй байдаг гэж байлаа. Ер нь шинээр тэтгэвэр тэтгэмж нэмэгдэх буюу өөрчлөгдөхөд л ачаалал ихэсч бужигнадаг гэж байлаа. Одоо 1 сая төгрөг өгөх сурагтай байгаа. Яг өгнө гээд тов нь гарчихвал ёстой овоорно доо. Одоо ч тэр мөнгөө асуусан хүмүүс их байгаа гэж байлаа. Оюутнууд эх орны хувь хишгээ сургалтын төлбөр хэлбрээр авч болдог бөгөөд энэ асуудлаар 2 эмэгтэй хүүхдийнхээ өмнөөс материал бүрдүүлж байгаа хэмээн явж байв. Тэдний нэг нь урд жил нь авч байсан учраас материал бүрдүүлэлтээ хийчихсэн ажлаа бүтээгээд гарсан. Харин нөгөө нь анх удаа авах гэж байгаа бололтой хуудас бөглөөд дахиад ирэхээс гэсээр гарсан юм. Нэг эмэгтэй 21 мянга нь ороогүй байна яасан юм бол гэж лавлахад Цагдаагаас асуу гээд гаргачихав. Ямар учиртайг нь асуусан ч мэдэхгүй ээ гэж байна. Гэтэл 10 минутын дараа өнөөх эмэгтэй дахиад л цагдаа манайхтай хамаагүй гэж байна ямар учиртай юм бэ гэсээр дахиад л ороод ирэв. Гэтэл Хүний сангийн мэргэжилтэн нь ямар сонин юм бэ манай дээр болохгүй гараад байна. Бид нар өөрсдөө цагдаагаас лавлая маргааш хүрээд ир хэмээн буцаав. Тодорхой шалтгаанаа сайн хэлж чадахгүй байгаа хэрнээ дараа ир гэж хэлсэн нь тэр эмэгтэйг нэлээн бухимдуулах шиг болсон. Түүнээс юм асуух гэсэн боловч уурласаар гарч одлоо. Тэр үер халамжийн ажилтанд 4 хүн хандсан бөгөөд жирэмсний тэтгэмж авах дэвтэр нээлгэх, нээлгэсэн ч мөнгө нь ороогүй байна гэж байв.

Энэ өдрийн хувьд иргэдийн хамгийн их хандаж байсан хүн нь мөн л Хүн ам гэр бүл хариуцсан мэргэжилтэн Хонголзул байв. Цайндаа орох хүртлээ тэрээр 12 хүнд үйлчилсэн. Энэ жилийг “Өрхийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан учраас түүнд хийх ажил их байгаа ажээ. Түүнд хандаж байгаа иргэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн талаар лавлаж, зөвлөгөө авч байв. Тус төсөл нь 4 дэх жилдээ зарлагдаж байгаа бөгөөд ноднин тэдний аймгаас 35 төсөл шалгарч 106 сая төгрөг авчээ. Хамгийн эхний жилдээ 2 төсөл шалгарч 6 сая, дараа жил нь 10 төсөл шалгарч 29 сая төгрөгийг иргэд авсан байна. Эндээс уг төсөл нь жил ирэх тусам хүрээгээ тэлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралд ихээхэн дэм болж байгаа нь харагдаж байна. Тэрээр шалгараагүй төслүүдээ авч үлдээд шалгарсан төслүүдтэйгээ харьцуулан

улмаар юун дээр алдсан талаар эргэж тухайн хүнд нь зөвлөдөг гэж байлаа. Үүний хажуугаар бас нэгэн иргэн хөдөлмөр эрхлэх чадваргүй гэр бүлийнхээ гишүүний өмнөөс төсөл бичиж болох уу хэмээн асууж байлаа. Гэвч энэ төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, улмаар тэдний өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн учраас энэ нь боломжгүй гэж байлаа. Мэргэжилтэн Хонгорзулын хувьд ачаалал ихтэй зогсоо зайп/й хүмүүс зөвлөгөө авч байсан боловч тэр бүгдэд нэг бүрчлэн хариу өгч байлаа. Цаасны хүрэлцээ муугаас иргэдийг төслийн удирдамж, бөглөх маягт, төсөл бичих загваруудыг хувилж авах 11 ширхэг цагаан цаастай ирэхийг шаардаж байв. Гэвч тэрийг нь мэдээгүй ирсэн иргэдийг аль болох буцаахгүйг хичээн ноорог цаасан дээр хэвлэж өгч байлаа. Энд мөн л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах сонирхол бага байдаг бөгөөд 250 орон тооны 120 нь эзэнтэй байгаа гэсэн.

Гурав. Иргэдтэй хийсэн ярилцлага

Иргэн Ганчимэг: Манай энд тэр хүнд суртал энэ тэр байхгүй ээ. Та нар харин билетийн кассан дээр очвол зүгээр дээ. Тэндхийн билет бичдэг хүмүүс нь хүнд сурталтай гэж жигтэйхэн. Дугаарлаж дугаарлаж очихоор билет байхгүй байна гэж хэлнэ. Хэдийд нь хаагуураа билетээ зардаг юм бүү мэд. Ааш муутай, хүмүүсийг дугаарлаж харьцсан хүмүүс л байгаа.

Төсөлд хамрагдах гэсэн иргэдээс шаардаж буй 11 хуудас цаасны талаар асуулаа.

Иргэн Батбаяр: Ах нь энэ төсөлд ноднин ороод шалгараагүй. Модоор юм хийдэг санаатай юм. Энэ жил энэ охиноос гайгүй сайн зөвлөгөө авлаа. Болох байх л гэж бодож байна. Тэр цаасны тухайд бас аргагүй биз дээ. Тэр олон хуудас юмыг чинь хүн бүрт өгнө гэхээр. Дээрээс нь төсвийн байгууллага болохоор хангамж материал нь тоотой л байдаг байлгүй.

Иргэн Х: Би саяхан энд шилжиж ирсэн. Шилжүүлгийнхээ бүх юмыг л уг нь хийлгэсэн юм. Гэтэл сая 21 мянга маань ороогүй маань тэрийгээ лавлах гэж ирлээ. Тэгсэн давхардаж орсон байна гэнээ. Яахаараа ч тэгдийн. Эд нар л хариуцлагагүй байхгүй юу. Гэр ойрхон болохоор маргааш эргээд ирж болно, хол хүмүүст бол ир яв гэдэг чинь бас л хэцүү шүү гэж байлаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Дүгнэлт:

Хамгийн түрүүнд Хөдөлмөр халамж үйлчилгээний төв нь бүх харьяа хэлтэс дасгуудтайгаа архив болон мэдээлэл чөлөөтэй солилцох нэг сүлжээгээр байнгын тасралтгүй хамтран ажиллах хэрэгтэй мэт санагдлаа.Цаашлаад тухайн нэг хүний талаарх төрийн бүх байгууллагыг хамарсан мэдээллийн өргөн сүлжээтэй бол тэр мэднэ энэ мэднэ гэж бие бие рүүгээ шидэхгүйгээр асуудлыг нэг дороос шийдэх ядаж л тэнд нь асуудал байна гэдгийг харах цонхтой болох юм. Энэ нь Сайншанд хотод 21мянгаа ороогүй шалтгааныг тодруулахаар ирсэн иргэнийг ямар ч тодорхой шалтгаангүйгээр Цагдаагийн байгууллага руу 2 удаа явуулсанаас тод харагдаж байлаа.

Үүнийг ажилтнууд ч хэлж байсан. Хэн нэгэн хүний мэдээлэл байхгүй, ямар нэг зүйл нь дутуу бол заавал иргэдийг нааш цааш нь явуулж чирэгдүүлэхгүйгээр дотоод сүлжээ бүхий мэдээллийн нэгдсэн сүлжээгээрээ хайж олдог бол аль аль талдаа цаг хэмнэж, хүндрэл чирэгдэлгүйгээр үйлчлэх боломжтой болох юм.

Мөн Сонгинохайрхан дүүргийн 1 хорооны хувьд хэдийгээр хотын захын дүүрэг ч гэлээ интернэтгүй байна гэдэг иргэдээсээ дутуу мэдээлэлтэй байхад хүргэж байсан.Төрийн албыг хүргэхэд хоёргүй сэтгэлээр зүтгэх ёстой боловч том жижиг гэлтгүй бүхий л шат дамжпагын ажилчдын тохь тухтай нөхцөлд ажиллах боломжийг нь бүрдүүлж өгөх ёстой мэт санагдсан. Энэ нь ялангуяа Сонгинохайрхан дүүргийн 1 хороонд тод ажиглагдсан бөгөөд хотын захад оршдог гэлтгүй тэнд анхаарлаа хандуулах нь эргээд түүгээр үйлчлүүлэх иргэдээ ч бодож буй хэрэг юм.

Миний очсон гурван газар алинд нь ч тулгамдаж байсан нэг асуудал бол хангамжийн асуудал байлаа. Ялангуяа 21мянгын бүрдүүлэлтэнд маш их цаас шаардагддаг, шилжилт хөдөлгөөн гарах болгонд дахин шинээр бүрдүүлэлт хийдэг зэрэг нь тэдэнд очдог цаасны хангамж болон хувилагч машины хорны хаана нь ч хүрдэггүй байна.Энэ нь эргээд иргэдэд хүрэх үйлчилгээн дээр нэмэлт татаас болж хүрч байна. Мөн захын хорооллын хороонд ажилтнуудын болон иргэдийг хамгийн их чирэгдүүлж зүйл нь хувилагч машины асуудал байсан. Тиймээс нэг бол энэ олон бичиг цаасны асуудлыг цэгцлэх, эсвэл тэдэнд очих хангамжийг сайжруулах шаардлагатай байна. Нэгэнт дээрхи наад захын хангамжийн асуудал нь гачигдалтай байгаа нөхцөлд иргэдэд хүрэх тараах материал байхгүй байсанд гайхах юм алга.

Мөн хөдөлмөр, халамжийн ажилтнуудын цаг ашиглалтанд тавих хяналтыг нарийн болгож, ажлын байран дээр байхгүй байх минут секунд тутам ард нь иргэд хүлээж байгаа гэдгийг марталгүй ажилдаа хариуцлагатай хандах хандлагыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

“ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАП ЧИРЭГДЭЛ” АЖИГЛАЛТ, ТАНДАЛТЫН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд болон хуулиар баталгаажуулсан эрхээ эдлэхэд ямар хүндрэл чирэгдэл учирч буйг тодорхойлох зорилгоор “Хүний эрх ба хүнд суртал, чирэгдэл” шалгалт, судалгааны ажлын зохион байгуулж байгаа билээ. Үүний хүрээнд 3-р сарын 12-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 1 хороонд дээрх судалгааны ажлын ажиглалт, тандалтыг хийсэн болно.

Нэг. Ажлын байрны нөхцөл байдал

Сонгинохайрхан дүүргийн 1 хороо нь 4 өрөө бүхий 1 давхар байшинд үйл ажиллагаагаа явуулдаг юм байна. Үүдээр нь ороход иргэдэд зориулсан мэдээллийн самбар өлгөөтэй байх ба ажлын зар нэлээд хувийг эзэлж байв. Хаалгануудын гадаа хорооны ажилтнуудын танилцуулга, холбоо барих утас, ажил үүргийг нь тавьжээ. Жижигхэн байшин учраас иргэд хүлээх сандалгүй тохь муутайн дээр их хүйтэн ажээ. Хорооны ажилтнуудын хувьд гадуур хувцастайгаа суух бөгөөд угаас тайлах ч аргагүй юм. Эмэгтэйчүүд нь ягаан куртик өмссөн байсан нь цаанаас нь авч өгсөн ажлын хувцас ажээ. Тиймээс энэ нь ажилчид болон үйлчлүүлж буй иргэдийн хувьд ч тухгүй санагдсан.

Хоёр. Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, захиргааны хэм, хэмжээ тогтоосон акт:

Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтнүүд нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиуд болон Засгийн газрын тогтоол, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаал, Нийгмийн халамжийн газрын даргын тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Гурав. Ажиглалт, тандалт

Шинэчилсэн цагийн хуваарийн дагуу хороо нь 08 цагаас орой 17 цаг хүртэл ажилладаг юм байна. Гэвч намайг 09 цаг гээд очиход хүн бараг байхгүй байж байгаад 10 дөхүүлээд цувж эхэлсэн. Тиймээс энэ цагийн өөрчлөлт нь тийм ч нүдээ олсон зүйл биш гэж харагдаж байсан. Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтэн нь нэг өрөөнд суудаг учраас тэдний өрөөнд ажиглалтаа эхэллээ. Халамжийн мэргэжилтэн Б.Бизьяасүрэнгийн хувьд хөдөрмөр эрхлэлтийн болон хүний хөгжил сангийн асуудлаа давхар хариуцдаг юм байна. Энэ нь түүнд хандах хүмүүсийн тоог ихэсгэж ачааллыг нэмэгдүүлж байсан. Хорооны ажилтнуудын хэлснээр өглөө 08-иас ажилдаа ирэхэд хүн бараг ирдэггүй. Харин эндхийн ажилчдын хувьд өглөө хүүхдээ цэцэрлэгт өгөхөд хүндрэлтэй байдаг гэнэ. Өглөө 08-д үйлчлүүлж сураагүй хүмүүс яг цайны цаг нь дөхөхөөр оволзож, цайны цагаас нь үргэлж хороодог гэнэ. Энэ нь бас л бухимдал үүсэх шалтгаан болдог ажээ. Хотын захад орших энэ хороо нь шилжилт хөдөлгөөн ихтэй дүүрэгт орно. Ихэвчлэн баруун аймгуудаас ирнэ. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор олон дахин нааш цааш явах тохиолдол их гардаг гэнэ. Хүний хөгжил сангийн мөнгөө авах гэсэн боловч нэр ороогүй байна, бүртгэл байхгүй байна гэсээр 2 хүн орж ирэв. Шилжилт хөдөлгөөн хийгдэхэд халамжийн дэвтрүүд дагаад хүрээд ирдэг бол хүний хөгжил сангийн бүртгэлийг заавал дахин хийж, олон хуудас бүхий хавтас үүсгэдэг

байна. Гадаадад байгаа хүмүүсийн мөнгийг итгэмжлэлээр их авдаг бөгөөд 1 хүн энэ асуудлаар орж ирэв. Саяхан 3-р сарын 1-ээс оюутны 500 мянган төгрөгийн материал хүлээж авч байгаа гэнэ. Тиймээс тэр асуудлаар 7 хүн хандсан. Тэр болгонд маягтын мөнгө 100 төгрөг хурааж аван бөглүүлж байсан. Эндхийн нэг асуудал нь дотроо канон буюу хувилагч машин байдаггүйтэй холбоотой үүсэж байна. Хорооны ажилчид өөрсдөө ч хажуугийн дэлгүүрийн хувилагч машинаар материалаа хувилдаг бөгөөд мөнгийг нь өөрсдөө гаргадаг. Иргэдийн бүрдүүлэх материал ч дандаа хувилуулах зүйл ихтэй байдаг учраас энэ нь нилээн бухимдал үүсгэдэг ажээ. Заримдаа тэр дэлгүүрийн хувилагч машин ажиллахгүй эсвэл муу гарах тохиолдол их байдаг учраас иргэд өөрсдөө дотроо канонтой байхад яадаг юм ийш тийш нь олон дахин явууллаа хэмээн загнадаг ажээ. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд үүдээр ороход л мэдээллийн самбарын дийлэнхийг ажлын байрны зар эзэлж байсан учраас энэ талын ажилд идэвхтэй хамрагддаг болов уу гэсэн сэтгэгдэл төрж байлаа. Гэтэл эсрэгээрээ иргэд ажилд ажилд орох сонирхол төдийлөн байдаггүй гэж байлаа. Энэ нь тэдэнд бэлнээр олгож буй хүний хөгжил сан болон халамжийн олон хэлбрээр олгож буй бэлэн мөнгөтэй холбоотой гэж байлаа. Уг нь судалгаагаар тэдний дүүрэг ажилгүйчүүдийн тоогоороо толгой цохихоор гардаг гэнэ. Нөгөө талаас нь авч үзвэл Хөдөлмөр халамжийн төвөөс зохион байгуулдаг мэргэжил олгох сургалтанд хүмүүс их хамрагддаг гэсэн. Сайн суралцвал тэндээсээ ажилтай болох боломжтой учраас үнэхээр ажил хийе гэсэн хүнд бол өгөөжтэй үйл ажиллагаа санагдсан. Мэргэжил олгох сургалтанд бүртгүүлэхээр 2 хүн орж ирэв. Гэвч одоохондоо эхлэх болоогүй эхлэхээр нь дуулгая хэмээн утсыг нь авч үлдсэн. Хүний хөгжил сангаас олгож буй мөнгөний нэг давуу тал нь иргэдийн бүртгэлд их нэмэртэй гэнэ. Учир нь шинэчилсэн бүртгэлд заавал хамрагдаж, тодорхой хаягтай хүн л энэ мөнгийг авах учраас хаяг тодорхой болгох, иргэдийнхээ тоог бодитой гаргах ач холбогдолтой ажээ.

Дөрөв. Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт:

Хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн нь дараах чиглэлээр иргэдэд үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэх;
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэх;
- Хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн өдөр тутмын ажлыг хариуцан зохион байгуулах;
- Хүний хөгжил сангийн тухай хууль, журмын дагуу иргэдэд хишиг хувь хүртээх ажлыг хариуцах;
- Хүн амын бүлгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, төслүүдийг зохион байгуулах;
- Хүн ам гэр бүлийн чиглэлээр мэдээ, судалгааг гаргаж, түүнд үндэслэн өрхийн амьжиргааг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийг сурталчилах, хэрэгжүүлэх зэрэг ажлууд;

Хорооны нийгмийн ажилтан нь дараах зорилтын хүрээнд иргэдэд үйлчилгээг үзүүлэн ажиллаж байв. Үүнд:

- Нийгмийн үйлчилгээний талаарх хууль тогтоомж, бодлого шийдвэр, үндэсний болон дэд хөтөлбөрүүд, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах, таниулах;
- Иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

- Хувь хун, гэр бүл, бүлэг, олон нийтэд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх, чадваржуулах, оролцоог хангах талаар зорилтот ажлуудыг зохион байгуулах;
- Холбогдох ажлын чиглэлээр судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлэх хяналт, шинжилгээ үнэлгээ хийх;

Энэ нь тэдний иргэдэд хүргэх мэдээллийн самбараас авсан ажлын чиг үүрэг бөгөөд яг өөрсдийнхөө ажлын байрны тодорхойлолтыг өгөх боломжгүй гэлээ.

Тав. Иргэдтэй хийсэн ярилцлага:

Толгойт 86-12 тоотод оршин суугч иргэн Саран: Манай хороонд хогны асуудал их хүнд байна. Урд нь хорооны хэсгийн ахлагч нар мөнгөө хураагаад хогоо цаг тухайд нь ачуулаад байдаг байсан. Гэтэл одоо гэрлийн мөнгөн дээр нэмэгдээд шууд авдаг болсноос хойш ачихаа больсон. Айл айлын хог хуримтлагдаж овоороод үнэр танар гэж авах юм байхгүй. Тэр эрүүл орчинд амьдарна гэдэг чинь байхгүй шүү дээ. Одоо хавар болж байна. Ийш тийшээ хог нь тараад хэлэх үг алга. Энийг одоо яамаар юм байгаан.

Толгойт 81.6 тоотод оршин суугч иргэн Х: Манайх саяхан хөдөөнөөс орж ирсэн. Ирснээсээ хойш хороогоороо л их эргэлдэж байна. Ажилд орохоор бүртгүүлээд өнөөдөр дуудахаар нь ирлээ. Боломжийн ажил л юм шиг байна. Цалин мөнгө нь жаахан бага юм. Гэхдээ бидэн шиг мэргэжилгүй хүмүүст энэнээс өөрөөр яахав дээ. Орно л гэж бодож байна. Манай энэ халамжийнхан гайгүй ээ. Харин газрын мэргэжилтэн л ажил ихтэй байдаг юмуу олдох нь ховор доо.

Толгойт 80-74 тоотод оршин суугч иргэн Баяраа: Ах нь газрын асуудлаар 2 дах удаагаа ирээд байна. Хөдөөнөөс саяхан орж ирсэн. Дүүгийндээ байгаа. Энэ хавьд газар авах гэсэн чинь өөрөө сул чөлөөтэй газраа олж ирээд хэл гэсэн. Гэтэл энд уулын орой дээр хүртэл гараад суучихсан байхад хаана нь газар байгааг мэдэхгүй байна. Баахан л явлаа. Өөрөө яваад газраа ол гэдэг чинь газар байхгүй ээ гэсэн үг юм бишүү. Сая газрын хүнээс нь дахиад асуулаа. Одоо болохоор бүр хол л юм яриад байна. Дараа хамт явахаар л боллоо.

СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ АЖИГЛАЛТ, ТАНДАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

“Хүний эрх ба Хүнд суртал, чирэгдэл” шалгалт судалгааны ажлын хүрээнд 2012 оны 3 дугаар сарын 09-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагаанд тандал, ажиглалтыг хийлээ.

Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга гадаад томилолтоор явсан тул зарим албан хаагчидтай уулзаж, “Хүний эрх ба хүнд суртал, чирэгдэл” ажиглалт, тандалтын удирдамжийг танилцуулж, улмаар удирдамжийн хүрээнд тухайн хэлтсийн үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт дүн шинжилгээ хийх, болон тус хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний орчин, албан хаагчдын ажпын ачаалал, мэдээллийн ил тод байдал, үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамжийн байдалд ажиглалт тандалт хийхээр халамжийн нэг цэгийн үйлчилгээний хэсгийг сонгон авсан болно.

1. Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс

Тус хэлтэс нь 2005 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын тушаалаар хуучин ХЭА, Халамжийн төвийг нэгтгэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс байгуулагдсан. Тус хэлтэс нь өнөөгийн байдлаар 64 ажиллагсадтайгаар дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 32 хорооны 52770 өрхийн 252300-д хүн амд хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ болон хүний хөгжил сангийн үйлчилгээ үзүүлж байна.

Тус хэлтэс нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд:

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвөлгөө өгөх, мэдээ мэдээллээр хангах
- Ажилд зуучлах,
- Мэргэжил олгох давтан сургалтанд хамруулах,
- Хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжих жижиг зээл олгох,
- Ажил олгогчийг дэмжих,
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулах,
- Шинээр бий болсон ажпын байрыг бүртгэх

Нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээнд:

Тэтгэвэр

- Ахмад настны халамжийн тэтгэвэр,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр,
- 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцгийн халамжийн тэтгэвэр
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Тэтгэмж

- Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж
- Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асарч буй иргэнд олгох тэтгэмж
- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авч өсгөсний тэтгэмж

Мөнгөн тусламж

- 3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа
- Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа
- 3 ба түүнээс тооны бага насны /14 хүртэл/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-т жилд нэг удаа
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа
- Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ Ахмад настанд тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үзүүлэх Алдар цолтой ахмад настанд хөнгөлөлт, тусламж үзүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үзүүлэх Хун ам, гэр бүлийн хөгжлийн талаархи гэрээ конвенци, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зэрэг үйл ажиллагаанууд явуулж байна.

2. Ажиглалт, тандалт хийсэн байдал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу Ханын материалын эцэст тусдаа 3 давхар байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Нэг цэгийн үйлчилгээний орчин нөхцлийн хувьд иргэдэд халамжийн үйлчилгээг 1 ахлах мэргэжилтэн, 6 мэргэжилтэн ажиллаж, нэг мэргэжилтэнд 5-6 хорооны иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байна. Мэргэжилтнүүдийн ажлын ачаалал сарын хугацаанд харилцан адилгүй байдаг ба гол төлөв сарын дунд үе буюу 15-наас 20-ны хооронд хувь хишиг хүртээх үйлчилгээний санхүүжилт орж ирсэн үед ачаалал ихтэй ажиллаж бусад үед өдөрт дунджаар нэг мэргэжилтэн 50-70 орчим хүнд халамжийн үйлчилгээ үзүүлдэг байна.

Ажил өглөө 8 цагт эхэлсэн боловч тус нэг цэгийн үйлчилгээний хэсэгт анхны үйлчилүүлэгч 9 цаг 20 минутанд ирсэн бөгөөд 10.30 цагаас хойш харьцангуй үйлчилгээ авах иргэдийн тоо нэмэгдэж байлаа. Албан хаагчидтай ярилцахад бүх нийтийн баяр ёслолын өмнөх болон дараах өдрүүд харьцангуй үйлчлүүлэгчид багатай байдаг тул бичиг баримт цэгцлэх зэрэг ажпуудаа амжуулдаг гэж байна.

Ажиглалтын хугацаанд нэг цэгийн үйлчилгээний 6 цонхон дээр ирж үйлчилгээ авч буй хүмүүсийн ачаалал харилцан адилгүй, дээд тал 45 иргэн, доод тал нь 17 хүн нэг цонхноос үйлчилгээ авсан ба үйлчилгээ авч буй иргэд ихэвчлэн тэтгэмжийн дэвтэр сунгах, тэтгэмж авах эрх нээлгэх материал өгөх, хөнгөлөлт эдлэх эрх нээлгэх, групп сунгуулах, мэдээлэл авах зэргээр нийт 160 орчим иргэд үйлчлүүлснээс ихэнх нь

бичиг баримтын бүрдэл дутуу гэсэн шалтгаанаар үйлчилгээг бүрэн авч чадалгүй буцаж байлаа.

Ажиглалт, тандалтын үеэр тус дүүргийн 3 хорооны иргэн Хорлоотой ярилцахад: “Ахмадуудад хиймэл шүд хийлгэсний үнийг олгодог гэж шүдний эмнэлгийн эмчээс сонсоод шүд хийлгэсэн баримтаа аваап ирсэн боловч хорооны тодорхойлолт дутуу байна гэсэн шалтгаанаар буцаж байна. Ер нь бол ахмад настангуудад ямар ямар төрлийн хөнгөлөлт эдэлдэг талаар мэдээлэл муу байна. Гол төлөв гадаа салхилж суухдаа бусад ахмадуудаасаа мэдээлэл сонсох юм. Түүнээс биш хороон дээгүүр орж гарч байдаг, янз бүрийн мэдээ мэдээлэл самбар дээрээ хаддаг л байх, настай хүмүүс чинь хараа муутай болохоор тэр болгоныг нь нэг бүрчлэн уншиж, танилцаж чадах ч үгүй юм, хорооны нийгмийн ажилтнууд тэр болгон та ийм ийм хөнгөлөлт эдлэх ёстой шүү гэж хэлж тайлбарлаад байх нь үгүй юмаа, ажил ихтэй хүмүүс хүн бүрт нэг бүрчлэн яриад тайлбарлаад суух зав ч байдаггүй байх. Одоо миний бичиг баримт дутуу болохоор хорооноос тодорхойлолт аваад маргааш дахиад л ирнэ дээ. Нэг талаасаа ямар ямар бичиг баримт бүрдүүлэх ёстойг асууж лавлалгүй шууд ирсэн бидний буруу л юм даа” гэж байлаа.

Тус дүүргийн хувьд зарим хороод алслагдсан байрлалтай хамгийн хол нь 32 дугаар хороо Партизанд буюу 60 км-ын хол байрладаг. Алслагдсан хороодын иргэдэд халамжийн үйлчилгээ хорооны халамжийн мэргэжилтэн дээр төвлөрөн шийдвэрлэгддэг бөгөөд хэлтсээс удирдлага арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, шийдвэрлэх боломжгүй асуудлуудын хувьд иргэдэд чирэгдэл учруулахгүй байдлаар зохион байгуулж, хороон дээр ажиллаж буй мэргэжилтнээр дамжуулан долоо хоног бүрийн 4 дэх өдөр хэлтэс дээр авч ирж шийдвэрлэдэг байна.

3. Дүгнэлт

Дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагаанд ажиглалт хийх явцад, үйлчилгээ үзүүлж буй байрны орчин нөхцөл боломжийн, халамжийн мэргэжилтнүүд өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журмын эмхэтгэл, гарын авлагаар хангагдсан, мэргэжилтнүүдийн ажлын ачаалал хэвийн байна гэж үзлээ.

Тухайн нэг цэгийн үйлчилгээний хэсэг төдийгүй тус хэлтсийн хувьд иргэдэд мэдээлэл хүргэж буй мэдээллийн самбар нь иргэдийн нүдэнд тусах газар байрлуулаагүй, суртчилгааны материалууд байдаг боловч иргэдэд түгээх, явдал хангалтгүй, иргэдэд ихэвчлэн мэргэжилтнүүдтэй ирж уулзаж мэдээлэл авч байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ТАНДАЛТ, АЖИГЛАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

2012 оны 3 дугаар сарын 6-ны өдөр “Хүний эрх ба Хүнд суртал, чирэгдэл” шалгалт судалгааны ажлын хүрээнд БЗД-ийн ЗДТГ-ын Нийгмийн хэлтсийн Хөдөлмөр нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаанд тандалт ажиглалт хийлээ.

БЗД-ийн ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, Хүний эрх ба хүнд суртал чирэгдэл, ажиглалт тандалтын удирдамжийг танилцуулсны дагуу Нийгмийн хэлтсийн дарга Б.Жавхлан Хөдөлмөр нийгмийн хамгааллын мэргэжилтэн Г.Ванчиндоржийн ажлын нэг өдрийн үйл ажиллагаанд ажиглалт тандалт хийхийг зөвшөөрлөө.

Тус дүүргийн Засаг даргын 2010 оны 503 дугаар захирамжаар баталсан “Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан эрх зүйн акт, бусад шийдвэр, бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнгийн нэгдсэн мэдээ гаргах журам” болон тухайн дүүргийн хэлтэс, албадын бүтэц зохион байгуулалт, тогтолцооны байдалтай хамааралтайгаар ЗДТГ-ын нийгмийн хэлтэст хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаа уялдаж, мэдээ тайлангаа тус хэлтэст гарган хүргүүлж байх зэрэг үндэслэлүүдийг харгалзан нийгмийн хэлтсийн хөдөлмөр нийгмийн хамгааллын мэргэжилтний үйл ажиллагаанд ажиглалт тандалт хийх нь төрийн албан дахь хүнд суртал чирэгдлийг бий болгож байгаа тогтолцооны доголдол, ажил үүргийн оновчгүй хувиарлалт байгаа эсэхийг тодруулахад дөхөмтэй гэж үзсэн болно.

НЗД-ын 2011 оны 648 дугаар захирамжаар дүүргүүдийн ажлын цаг 08-17 цагийн хооронд байхаар зохицуулагдсны дагуу тус дүүргийн ажил өглөө 08 цагт эхэлж байна. Хүний эрх ба хүнд суртал чирэгдэл, ажиглалт тандалтын үйл ажиллагааг 10 цагт эхэллээ.

1. Ажиглалт, тандалтын үеэр цуглуулсан мэдээ, мэдээлэл

Баянзүрх дүүрэг өнөөдөр 124,4 мянган га газар нутагтай, Засаг захиргааны нэгж болох 28 хороотой, 70063 өрх, 265997 хүн амтай, хөдөлмөрийн насны хүн ам 150,9 мянга буюу 56,7 хувийг эзэлж байна. Дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн ам 2000 онд 0,9 мянга байсан бол 2010 онд 1,1 мянга болсоноос үзэхэд жил ирэх тутам хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо нэмэгдсэн байна.

Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоол, Засгийн газрын 205 дугаар тогтоол, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 175 дугаар тушаал, Улсын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2005 оны 13 тоот тушаалыг тус тус үндэслэн дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн алба, Нийгмийн халамжийн төвийг нэгтгэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нэртэйгээр 2005 оны 1 дүгээр сард байгуулагдсан. Улсын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2005 оны 13 дугаар тушаалаар хэлтсийг 17 орон тоотойгоор баталсаны дагуу удирдах ажилтан 1,

гүйцэтгэх төрийн албан хаагч 11, үйлчилгээний 5 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус хэлтэс нь БЗД-ийн хэмжээнд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай”, “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай”, “Нийгмийн халамжийн тухай”, “Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай”, “Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай” хуулиуд болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол шийдвэр, Монгол Улсын Засгийн газар, нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангаж, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн халамжийн төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж ажилладаг байна.

Тус хэлтэс нь үйл ажиллагааны үндсэн чиглэлээ дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хэлтэст хандсан ажилгүй болон ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг судлаж бүртгэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах
 - Ажил олгогчоос сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч шаардлагатай ажиллах хүчээр хангах
 - Ажил мэргэжилгүй иргэдийг мэргэжил эзэмшүүлэх анхан шатны болон давтан сургалтад; хувиараа аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийг аж ахуй эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад тус тус хамруулах
 - Ажлын байрыг нэмэгдүүлэх аж ахуйн нэгж, иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжиж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авахад нь дэмжлэг үзүүлэх
 - Хөдөлмөр зарцуулалт ихтэй, нарийн мэргэжил шаардахгүй нийтийг хамарсан ажилд ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг зохион байгуулан оролцуулж түр ажлын байраар ханган ажлын хөлсийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох
 - Хэлтэст удаан хугацаагаар бүртгэлтэй байсан ажилгүй иргэнийг авч 6 сараас дээш хугацаагаар тогтвор суурьшилтай ажиллуулсан; мэргэжилгүй иргэнийг үйлдвэрлэл дээрээ сургалтад хамруулан мэргэшүүлж ажлын байраар хангасан ажил олгогчид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу урамшуулал олгох
 - Ажлаас халагдсан иргэдийн ажилгүйдлийн тэтгэмжийг тооцон олгох
 - Хөнгөлөлттэй нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгоод тэтгэвэр нь зогсоогдсон иргэдэд нөхөн олговор олгох
- Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу нийгмийн эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон нэн ядуу амьдралтай иргэдэд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх
- Нийгмийн халамжийн үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн хэлбэрээр хөнгөн шуурхай уян хатан зохион байгуулах явдал юм.

2. Ажиглалт тандалт хийсэн байдал

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс нь ЗДТГ-аас тусдаа 2 давхар бүхий байртай. Байрны орчин нөхцлийн хувьд боломжийн. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас ерөнхий удирдлагаар хангаж ажилладаг ба Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулах замаар үйл ажиллагаагаа тайлагнадаг тогтолцоотой байна.

БЗД нь хүн амын төвлөрөл, шилжилт хөдөлгөөн ихтэй байдаг зэргээс хамаарч, тус хэлтсийн орон тооны нэг албан хаагч нэг өдөрт бага ачаалалтай үед 50-70 хүнд, их ачаалалтай үед 250-300 хүнд үйлчилдэг байна.

Харин ЗДТГ-ын нийгмийн хэлтэс нь Нийслэлийн Засаг даргын 423 дугаар захирамжаар 2001 онд байгуулагдсан бөгөөд дүүргийн хэмжээнд Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, дүүргийн нутаг дэвсгэр дээрх нийгмийн салбарын байгууллагуудыг төрийн удирдлагаар хангаж ажиллахаар байна. Нийт 1 удирдах албан тушаалтан, 5 албан хаагч бүхий 6 орон тоотой байна.

Дүүргийн хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолттой танилцлаа. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн нь хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамж үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх чиглэлээр төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бодлогын санал боловсруулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг удирдан зохион байгуулах үндсэн үүрэгтэй бөгөөд хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, харж хандах хүнгүй хүүхэд, хөгшдөд халамж үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, шинжилгээ үнэлгээ хийх, бодлого тодорхойлж хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг хангаж ажиллах ёстой байна.

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилт Баянзүрх дүүрэгт 2010 онд” тайлангаас үзэхэд “Ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх асуудлын хүрээнд 2011 оныг дүүрэгт “Хөрөнгө оруулалт-Нийгмийн үйлчилгээний жил” болгон зарлаж, ядуурлыг бууруулах чиглэлээр дүүрэгт олон улсын байгууллагын дэмжлэгээр хэд хэдэн төслүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр, Тогтвортой амьжиргаа төсөл, Иргэдийн оролцоонд тулгуурласан нөхцөл байдлыг сайжруулах төсөл, Нийтийн аж ахуйг сайжруулах зэрэг төслүүд багтаж байна. Дүүргийн хэмжээнд ядуурлын түвшин, гүнзгийрэлтийг гаргасан сүүлийн 3 жилийн мэдээ байхгүй байгаа нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудад дэвшүүлсэн “Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах” гэсэн зорилтод хүрэхэд багагүй бэрхшээл учрах хандлагатай байна” гэжээ.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа ч хүн амын ядуурлын түвшин буурахгүй, өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2010 оны судалгаагаар ядуурлын түвшин 39.2 хувьд хүрчээ. Өрхийг гишүүдийнх нь оролцоо, санаачилга дээр тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн зэрэг багц үйлчилгээгээр дэмжин хөгжүүлж, дээрх Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын 2012 оны 2 дугаар тогтоолоор Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталсан. БЗД-ийн хэмжээнд тус хөтөлбөрт НХХЯ-наас хийсэн судалгаагаар тодорхойлсон 1179 өрх айлыг хамруулахаар төлөвлөжээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэний ярьж тайлбарласнаар үүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа, ахмад настны судалгаа, дайнд оролцож байсан ахмад настны судалгаа, халамжийн төдүүд дэх хүүхдийн судалгаа, хөдөлмөр эрхлэдэг, эрхэлдэггүй иргэдийн судалгаа зэргийг

гаргадаг. Эдгээр судалгаатай танилцах шаардлагатай гэвэл албан бичгээр хандаж авах зөвлөж байна. Шууд танилцуулах боломжгүй гэлээ. Дээрх судалгааны талаарх нарийвчилсан тоог хэлэх боломжгүй, одоогоор хороодоос шинэчлэн хүргүүлсэн маягтын дагуу судалгаа мэдээг ирүүлж байна. Ер бол халамж үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийг хороодын дэргэдэх амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрээр тодорхойлдог. Тус зөвлөлд хорооны засаг дарга, зохион байгуулагч, халамжийн ажилтан, хэсгийн ахлагч нар орж ажилладаг байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэний иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалтай танилцлаа.

Өргөдөл гомдлыг 14 хоногт багтаан шийдвэрлэх журамтай байна. Тус мэргэжилтний гар дээр 14 өргөдөл байгаагаас 10 өргөдлийг судалж шийдвэрлэхээр Засаг даргад танилцуулж байна. Ирж байгаа өргөдлийн дийлэнх нь гэр олгох асуудлаар, асрамжийн газарт хүүхэд шилжүүлэх, асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоолгох талаар, хүүхэд асрамжийн газраас үрчлэн авах зэрэг асуудлаар ханджээ. Харин эмчилгээний зардал гаргуулах, нүүрс түлээ, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудлаар гаргасан өргөдөл гомдлыг хөдөлмөр халамжийн хэлтэст шилжүүлж шийдвэрлүүлдэг байна.

Тус дүүргийн 2011 онд хүлээн авсан өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалтай танилцахад нийт бичгээр хандаж ирсэн 932 өргөдөл гомдлоос гэр олгох, газар хүссэн, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхийг хүссэн 219 өргөдөл буюу 23.4 хувийг эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд гэр хүссэн өргөдөл ихээр ирдэг байна. Иргэдийн гэр хүссэн хүсэлтийн хороод шууд хүлээн авч дүүрэгт шилжүүлдэг, очер дараалал ихээр үүсгэдэг энэхүү байдлыг зохицуулах журмаар Дүүргийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн хурлаар “Гэрийн сан” болон УИХ-ын гишүүдийн тойрог хувиарласан мөнгө буюу бүсийн хөгжлийн сан зэргээс Засаг даргын 2010 оны 503 дугаар захирамжаар баталсан “Гэр олгох журам”-ын дагуу иргэдэд гэр олгодог байна. Ажиглалт тандалын үеэр гэр хүссэн 3500 иргэний бүртгэлтэй байх бөгөөд өргөдлийг хангаж шийдвэрлэх боломж хязгаарлагдмал, төсөв санхүүгээс хамаарч жилд янз бүр тоо хэмжээгээр гэр олгож шийддэгээс иргэд бухимдах, хүнд суртал гаргадаг гэсэн асуудал их гарч байна. Тухайлбал, 2011 оны байдлаар гэр хүссэн 151 хүний өргөдлийг хүлээн авч 3-ыг нь хангаж шийдвэрлэсэн бол 148-ыг очер дараалалд оруулж бүртгэсэн байна. Сүүлийн 3 жилд нийтдээ 920 гэр олгосон байна. Гэр хүссэн өргөдлийг зарим иргэд жил бүр гаргадаг зэргээр бүртгэл давхардах байдал гардаг тул нэгдсэн бүртгэл судалгааг гаргах замаар иргэдэд өөрсдийн очер дугаар хэдэд байгааг харах боломжийг бүрдүүлж өгчээ.

Ажиглалт тандалтын үеэр гэр олгох хүсэлт гаргасан дугаар хорооны иргэн Чимэдмаа ирж уулзлаа. Тэрээр 2005 онд хөдөөнөөс шилжин ирж 2006 онд БЗД-ийн Улаанхуран хорооны Засаг даргад гэр хүссэн өргөдөл гаргасан. Гэвч түүний өргөдөл дүүрэгт 2008 оноос бүртгэлд орсон байна. 2008 онд сонгуулийн үеэр нэр дэвшигч нарт болон Дэлхийн Зөн олон улсын байгууллагад хүртэл өргөдөл гаргасан байна. 2010 онд БЗД-ийн 5 хороонд шилжиж ирээд гэр олгох хүсэлт гаргасан өөрийн өргөдлийн талаар БЗД-ийн ЗДТГ-т 3 удаа биечлэн ирж уулзжээ. 2011 оны 5 сард НЗДТ-ын орлогч дарга Баатарзоригт дахин өргөдөл гаргасан боловч түүний

өргөдлийг дүүрэгт шилжүүлсэн байсан тул ирж уулзсан боловч очер дугаараараа явж байна гэсэн хариу өгчээ. Иргэн Чимэдмаа нь гэр олгох асуудлаар 5 удаа бичгээр өргөдөл гаргаж, 8 удаа биечлэн ирж уулзан, утсаар байнга лавлан асууж иржээ.

Үдээс хойш Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн БЗД-ийн 53 дугаар сургууль дээр зохион байгуулж байгаа “Нэг зүрхний хайр” аяны хүрээнд зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаанд оролцов. Үүний дараа Засгийн газраас 2012 оныг Өрхийн хөгжлийг дэмжих жил болгон зарлаж дүүргийн өрхийн хөгжлийг дэмжих нээлттэй арга хэмжээг зохион байгуулах ажлыг нийгмийн хэлтсээс дүүргийн хэмжээнд нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор түүний бэлтгэл ажлыг хангах гээд ачаалал ихтэй байгаагаас сонирхсон асуултад тодруулга тайлбар хийх боломжгүй байлаа.

3. Дүгнэлт

БЗД-ийн ЗДТГ-ын байр 2010 онд шинээр ашиглалт орсон, дүүргийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл сайтай байлаа. Харин иргэд өөрсдийн сонирсон мэдээлэл хүлээн авах боломж хомс, иргэдэд зориулан мэдээллийг хүртээмжтэй байдлаар хүргэх орчин нөхцөл бүрдээгүй байна. Иргэдэд зориулсан мэдээллийн самбар, үйлчилгээний талаар танилцуулсан тараах материал хомс зэргээс иргэд тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн ирж уулзан мэдээллийг авч байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн ажлын байрны тодорхойлолтод заагдсан зорилго зорилтыг хангах, үндсэн үйл ажиллагаагаа хийхээс илүүтэйгээр дайвар, техник ажпууд ихээр хийж байна. Ахмад настан, хөгжпийн бэрхшээлтэй иргэд харж хандах хүнгүй хүүхэд хөгшид зэрэг төрийн үйлчилгээнд зайлшгүй хамрагдах иргэдийн бүртгэл судалгаа хангалтгүй, тэдгээр иргэдэд хүрч байгаа халамж үйлчилгээний бодлого хир их нийцтэй байгаад дүн шинжилгээ хийх, нийгмийн халамж үйлчилгээний чанар хүртээмжийг судлан, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамж үйлчилгээний хүрээг оновчтой тодорхойлох талаар тодорхой санал санаачлалыг гаргаж хэрэгжүүлэх зэрэгт анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

А. ТАНИЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар	2. Нэгж [^] йн нэр Нийгмийн хэлтэс	
3. Ажлын байрны нэр: Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн	3.1. Албан тушаалын ангилал: Дэс түшмэл	5.2, Албан тушаалын зэрэглэл: ТЗ-4
4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Нийгмийн хэлтсийн дарга	4.1. Албан тушаалын ангилал: Ахлах түшмэл	5.3. Албан тушаалын зэрэглэл: ТЗ-7
5. Ажлын байрны [!] шууд харьяалан удирдах албан тушаал		

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	Дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамж, үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх чиглэлээр төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бодлогын санал боловсруулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг удирдан зохион байгуулах	
2. Ажлын байрны үндсэн зорилт	2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1.Ажлын байрны зорилгын дагуу холбогдох хууль, тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, холбогдох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.	Эд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	
2.Дүүргийн удирдлагуудыг ажлын байрны чиг үүргийн дагуу мэдээ, мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх.	нэн зөв мэдээллээр хангаж, өргөдөл, гомдол, санал, хүсэлт хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн байна.	
3.Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, харж хандах хүнгүй хүүхэд, хөгшидөд халамж үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх.	Нийгмийн үйлчилгээ зорилтот бүлэгт хүрч, дүүргийн нийгмийн үйлчилгээний хүрээ өргөжсөн байна.	

3. Ажлын байрны гол үйл ажиллагаа	3.1. Хугацаа, хувиар
Ажлын байрны 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд :	50
2.1.1 .Холбогдох хууль, тогтоомжийн дагуу дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлого боловсруулан, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамж, үйлчилгээний хүрээг өргөтгөхөд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.	
2.1.2. Ажлын байрны зорилгын хүрээнд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлж, мэргэжил арга зүйн дэмжлэгийг холбогдох байгууллагад бодлогын түвшинд үзүүлэх.	
Ажлын байрны 2 дүгээр үндсэн зорилтын хүрээнд:	35

I 2.2.1. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмий

халамж, үйлчилгээний хүрээг өргөтгөх чиглэлээр бодлогын санал төсөл боловсруулах 2.2.2.Энэ чиглэлээр дүүргийн удирдлагуудыг мэдээ мэдээллээр хангах. гарах бодлого, шийдвэрт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх 2.2.3.Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс ирсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх, халамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах	
Ажлын байрны 3 дугаар зорилтын хүрээнд:	10
2.3.1 Ажлын байрны 1, 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжиж байгаа үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх 2.3.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, харж хандах хүнгүй хүүхэд, хөгшидөд үзүүлж буй нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг судлан, бодлогын зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх	
Ажлын байрны зорилтын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа	5
1 .Байгууллагаас зохион байгуулж буй урлаг, спортын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох 2.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлж, тайлагнах.	

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай	
1.1. Ерөнхий шаардлага	Боловсрол	Бакалавр	Магистр	
	Мэргэжил	Нийгмийн ажилтан	Төрийн захиргаа	
	Мэргэшил	Мэргэшсэн нийгмийн ажилтан		
	Туршлага	Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан	Төрийн албанд 3-аас дээш жил ажилласан	
	Ур чадвар	» Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй ® Багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай э Үйл ажиллагаанд задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргах в Компьютерийн хэрэглээний програмууд ашиглах ® Албан хэрэг хөтлөх стандартын дагуу бичиг баримт боловсруулах		
	1.2. Тусгай шаардлага:	® Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих ® Нууц хадгалах		Илүү цагаар болон хуулиар тогтоосон онцгой нөхцөлд дайчлагдан ажиллах

Г. ХҮЧИН ЗҮЙЛС

! 1. Ажлын байрны хэрилцах сүбъект

1.1. Байгууллагын дотоод талд } байгаа	1.2. Байгууллагын гадна талд байгаа	
® Засагдарга » Засагдаргынзөвлөх ® Засаг даргын орлогч <» Тамгын газрын дарга • Нэгжийн дарга кар ® Ажилтан, албан хаагчид	® Улсын Их. Хурлын гишүүн ® Ерөнхийлөгчийн Тамгын газар * Яам, агентлаг « Нийслэлийн Засаг даргын Тамгын газар; нийслэлийн хэрэгжүүлэгч агентлаг ® Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөл » Ажлын хэсэг, мэргэжлийн баг * Олон улсын болон иргэний оролцооны байгууллагын төлөөлөл ® Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн зорилтын дагуу ажлын байрны чиг үүргийн хүрээнд Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, хэлтсийн даргын өмнө хариуцлага хүлээнэ.	
3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл	3.1. Санхүүгийн	Цалин, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдэл, шагнал, урамшил, тэтгэмж
	3.2. Материалын	Албан ажлын өрөө, тавилга. холбогдох техник хэрэгсэл
	3.3. Хүний	
	3.4. Бусад	Эрүүл ахуйн ба аюулгүйн шаардлага хангасан цэвэрлэгээ, үйлчилгээ, телефон утас
4. Ажлын байрны нөхцөл	4.1. Ердийн нөхцөл	Ажлын хэвийн орчин, нөхцөлд ажиллана
	4.2. Онцгой нөхцөл	Хууль тогтоомжийн дагуу шаардлагатай тохиолдолд онцгой нөхцөлд ажиллана.

Д. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан
Албан тушаалын нэр: Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга -Бямбацогт 2011 оны дугаар сарын -ны өдөр	Албан тушаалын нэр: Засаг даргын Тамгын газрын дарга Д.Баатарням 2011 оны дугаар сарын -ны өдөр

1. Энэ хугацаанд Засаг дарга, түүний тамгын газарт бичгээр ирүүлсэн 932 өргөдөл гомдлыг заавар журмын дагуу цаг тухайд нь бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж дүүргийн удирдлагуудад танилцуулан заалт авч асуудлыг шийдвэрлэх албан тушаалтанд шилжүүлснээс- Хуулийн хугацаанд хариу өгсөн нь 906 /97,2%/, хугацаа болоогүй байгаа өргөдөл 23/2,4%/, хугацаа сунгасан өргөдөл 3 /0,3%/-г эзэлж байгаа ба өргөдөл гомдлын шийдвэрлэлт 97,2%-тай байна.

- Хэдийгээр хуулийн хугацаанд хариу өгсөн өргөдөл 97,2%-тай байгаа ч асуудлыг бүрэн шийдэж, боломжтой хариу өгсөн нь 67,5%-тай байна. Шууд шийдвэрлэх боломжгүй удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал болох гэр, газар олгохыг хүссэн, нийгмийн асуудлаа шийдүүлэхийг хүссэн өргөдлүүдийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Эдгээр өргөдөл нь 23,4%-г /219/ эзэлж байна.

2. Нийт ирсэн өргөдөл болон, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь дараах байдалтай байна.

№	Хэлтэс, нэгжийн нэр	Бүгд	Хуулийн хугацаанд хариу өгсөн				Хугацаа болоогүй байгаа	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрсэн
			Хангаж шийдсэн	Дараа лалд бүртгэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Боломжгүй хариу өгсөн			
1	Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой	17	17						
2	Орон сууцн хүссэн	14		10 /орон сууцны квотод хамрагдах хүсэлтэй албан хаагч			4 /иргэдэд олгох боломжгүй/		
3	Гэр хүссэн	151	3	148					
4	Мөнгөн тусламж дэмжлэг, эмчилгээ сувиллын зардал хүссэн	101	66	17	3	13	2		
5	Ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх, ажлын байртай болохтой холбоотой асуудлаар	63	58	4 /нөөцөнд бүртгэсэн/			1		
6	Газар хүссэн, газрын асуудлаар	146	57	40	13	17	19		
7	Шагнал урамшудаатай холбоотой	4	4						
8	ААНБ, СӨХ-тэй холбоотой асуудлаар	15	12		3 /Албан тоотоор уламжи				

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

9	Дэд бүтцийн асуудлаар	14	12		лилсан/ 2 /Албан тоотоор уламжилсан/				
10	Нийтийн тээвэртэй холбоотой	1	1						
11	Хөрөнгө оруулалт, зээл тусламжтай холбоотой	49	48 дэмжсэн/			1 /шаардлага хангаагүй/			
12	Бусад /хөдөлмөр, нийгмийн хамгаалалал, иргэний бүртгэлтэй холбоотой асуудлаар гэх мэт/	357- /156/	352		5 /Албан тоотоор уламжилсан/				
Нийт		932	630	219	26	31	23	3	
Хувь			67.5	23.4	2.7	3.3	2.4	0.3	

2011 онд Тамгын газрын хэмжээнд 932, дүүргийн 28 хорооны 159212, нийт дүүргийн хэмжээнд 240950 иргэний өргөдлийг хүлээн авч, шийдвэрлэн хариу өгч ажилласан байна. Улирал бүр ИЗДТГ-т өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хүргүүлж байна.

Тамгын газарт бичгээр хандаж ирүүлсэн өргөдлийн 16.7% /156/ нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар буюу асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, асрамж болон сувиллын цэцэрлэгт хүүхдээ өгөх, буцаан авах өргөдлүүд эзэлж байна.

10,8% нь мөнгөн тусламж дэмжлэг, эмчилгээ сувиллын зардал хүссэн иргэд болон албан хаагчид эзэлж байна. Өргөдлийг ангилбал дараах байдалтай байна

-Нийгмийн асуудлаа шийдүүлэхийг хүссэн 27 албан хаагчаас 10 албан хаагчид-38 сая төгрөг

-Дотоод журмын дагуу мөнгөн тусламж хүссэн 34 албан хаагчид - 18,224,806

-Мөнгөн тусламж хүссэн 12 иргэнд- 7,170,000 төгрөгийг тус тус олгож, 2011 онд нийт 66 иргэд болон албан хаагчдад 63,394,806 төгрөгийг олгосон байна.

15-20% нь гэр хүссэн өргөдөл эзэлж байна. Гэр хүссэн иргэдийн хүсэлтийг хороод хүлээн авч шууд шилжүүлж байгаа нь өргөдлийн дарааллийг ихээр үүсгэж байгааг зохицуулах зорилгоор ДИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар “Гэрийн сан”, Гэр олгох журам”-ыг батлуулан, мөрдөн ажиллаж байна. Мөн гэр хүссэн 3000 гаруй иргэний өргөдөл хороо хороогоор дугаартай байсныг цэгцэлж, нэгдсэн нэг дугаарт оруулж, ирсэн он сарын дугаараар бүртгэдэг болсноор иргэд нийт гэр хүссэн иргэдийн хэддүгээрт бичигдсэн дугаараа харахад хялбар болсон.

Зарим гэр хүссэн иргэд гэрийн дараалал болоогүй байгаа бол өргөдлөө нийгмийн халамжаар солих, өөр тусламжид хамруулах талаар хүсэлт гаргадагч тухайн хүнд ямар чиглэлийн тусламж, үйлчилгээ хэрэгтэй байгааг ТЗУХ тогтоох боломжгүйгээс дахин шинээр өргөдөл бичүүлдэг ба хуучин өргөдлийг шийдвэрлэсэнд тооцож хаадаг нь иргэдэд горийн хүнд сургалтай гэсэн буруу ташаа ойлголтыг байнга төрүүлж, бухимдуулж байсан учраас гэрийн өргөдлийг нийгмийн хэлтэст шилжүүлж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 9 ДҮГЭЭР ХОРООН ДЭЭР ХИЙСЭН АЖИГЛАЛТ, ТАНДАЛТЫН ТАЛААРХ ИЛТГЭХ ХУУДАС

2012 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын “Хүний эрх ба хүнд суртал, чирэгдэл” шалгалт, судалгааны ажлын хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд болон хуулиар баталгаажуулсан эрхээ эдлэхэд ямар хүндрэл чирэгдэл учирч буй байдлыг тодорхойлох зорилгоор 2012 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08 цагаас 12 цаг хүртэлх хугацаанд Нийслэлийн Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороонд тандалт, ажиглалтын ажлыг хийлээ.

Нэг. Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны танилцуулга:

Тус хороо нь 1974 оны 9 дүгээр сард Амгалангийн 7 дугаар хорооноос тасран 370-ад өрхтэй 1400 гаруй хүн амтай байгуулагдсан. Дүүргийнхээ нутаг дэвсгэрийн зүүн хойд талд Шар хадны орчимд байрладаг. Хороо нь 8 хэсэгтэй, 48 га нутаг дэвсгэртэй. 2010 оны Хүн Ам Орон Сууцны Улсын тооллогоор 3025 өрх, 11945 хүн амтайгаар тоологдсон нийслэлийн захын хороодын нэг болж өргөжиж байгаа, хөдөө орон нутгаас шилжин суурьшигчид ихтэй хороо байна. Хороо нь 8 хэсэгтэй ажиллаж байна.

Хороо нь бүтэц, зохион байгуулалтын хувьд хорооны засаг дарга С.Наранцэцэг, иргэд нийтийн хурлын тэргүүлэгчдийн дарга С.Доржсумьяа, хорооны зохион байгуулагч, иргэний бүртгэл хариуцсан ажилтан, нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтэн, хэсгийн ахлагчид гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Хорооны нийт иргэдийн 15,3 хувь нь амьдралын түвшингээс дээгүүр, 61 хувь нь дундаж, 23,7 хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур буюу ядуу амьдарч байна¹.

Хороо нь ажлын өдрүүдэд өглөөний 08.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл цагийн хуваариар ажилладаг байна.

Хоёр. Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, захиргааны хэм, хэмжээ тогтоосон акт:

Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтнүүд нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиуд болон Засгийн газрын тогтоол, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаал, Нийгмийн халамжийн газрын даргын тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг байна.

Гурав. Хорооны иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа байрны нөхцлийн талаар:

¹ Нийслэлийн Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны танилцуулга 2012 он

Баянзүрх дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтын хүрээнд 2011 оны 12 дугаар сарын 15-нд хорооны цогцолбор гурван давхар барилгыг барьж ашиглалтанд оруулсан байна. Уг барилгын нэгдүгээр давхарт хурлын танхим, цагдаагийн хэсэг, хоёрдугаар давхарт хороо, гуравдугаар давхарт өрхийн эмнэлэг ажиллаж байв.

Хороо байрны нөхцөл байдлын хувьд шинээр баригдсан, дулаан, тохилог боловч талбай багатай, иргэд үйлчлүүлэх дарааллаа хүлээж байхдаа суух нэг ч сандал байхгүй, хүлээлгийн танхимгүй байв.

Дөрөв. Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаанд ажиглалт хийж, тэмдэглэл хөтөлсөн байдал:

Тухайн өдөр хороон дээр ажиллах хугацаанд нийгмийн халамж хариуцсан мэргэжилтнээр 17 орчим хүн, хорооны нийгмийн ажилтнаар 2 хүн нийтдээ 19 хүн үйлчлүүлсэн. Хорооны ажилтнууд тухайн өдөр ажлын ачаалал бага, цөөн иргэд үйлчлүүлж байгаа талаар яриу.

Иргэд дараах үйлчилгээг авч байв. Үүнд:

- Иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн, огт авч байгаагүй, гадаадад амьдарч байгаад ирсэн, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаж байгаагүй гэх зэрэг баримт бичгийн зөрчлийн улмаас Хүний хөгжил сангаас олгож буй хишиг хувиа хүртэж чадаагүй иргэд;
- Хүний хөгжил сангаас олгож буй хишиг хувийн оюутны сургалтын төлбөрт олгож буй 500,000 төгрөгийг авах;
- Эхийн 1, 2 дугаар одонтой эхчүүдэд олгож буй мөнгөн тэтгэмжийг авахтай холбоотой;
- Ажил хайж байгаа, ажил олж өгөхийг хүссэн;
- Халамжийн сангаас олгодог хүүхэд асарсны тэтгэмжээ авах, түүнийг авахтай холбоотой бичигт тэмдэглэл хийлгэх гэх мэт.

Тав. Хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт:

Хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн нь дараах чиглэлээр иргэдэд үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэх;
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэх;
- Хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн өдөр тутмын ажлыг хариуцан зохион байгуулах;
- Хүний хөгжил сангийн тухай хууль, журмын дагуу иргэдэд хишиг хувь хүртээх ажлыг хариуцах;
- Хүн амын бүлгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, төслүүдийг зохион байгуулах;
- Хүн ам гэр бүлийн чиглэлээр мэдээ, судалгааг гаргаж, түүнд үндэслэн өрхийн амьжиргааг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийг сурталчилах, хэрэгжүүлэх зэрэг ажлууд;

Хорооны нийгмийн ажилтан нь дараах зорилтын хүрээнд иргэдэд үйлчилгээг үзүүлэн ажиллаж байв. Үүнд:

- Нийгмийн үйлчилгээний талаарх хууль тогтоомж, бодлого шийдвэр, үндэсний болон дэд хөтөлбөрүүд, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах, таниулах;
- Иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх, чадваржуулах, оролцоог хангах талаар зорилтот ажлуудыг зохион байгуулах;
- Холбогдох ажлын чиглэлээр судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлэх хяналт, шинжилгээ үнэлгээ хийх;

Зургаа. Мэдээллийг олон нийтэд түгээж буй байдал:

Хорооны зүгээс ямар нэгэн мэдээллийг олон нийтэд, иргэдэд дараах байдлаар хүргэдэг байна. Үүнд:

- Гудамжны үзүүр, айлын хашааны гадна талд, худаг, автобусны буудал, дэлгүүр зэрэг олон хүнтэй газруудад зарлал наах;
- Хэсгийн ахлагч нараар дамжуулан айл айлд амаар зар тараах;
- Шаардлагатай тохиолдолд утсаар холбогдож ойр хавийхаа болон хөрш зэргэлдээ айлуудад нь зар тараалгах;
- Хорооны мэдээллийн самбарт зарлал тавих зэргээр олон нийтэд зар, мэдээллийг түгээдэг байна.

Дээрх байдлаар мэдээллийг түгээхэд хүн бүрт хүрдэггүй, бүрэн дүүрэн, бодитой мэдээлэл очдоггүй, ихэнх хүмүүс мэдээллийг авч чаддаггүй талаар албан хаагчид ярьж байв.

Долоо. Хороогоор үйлчлүүлж буй иргэдтэй хийсэн ярилцлагын талаар:

Хороогоор үйлчлүүлж байгаа иргэдийн ихэнх нь хорооны засаг даргаас тус хороонд оршин суудаг нь үнэн болох талаар тодорхойлолт авахаар ирж байв. Иргэний бүртгэл хариуцсан ажилтанаар үйлчлүүлэхээр ирсэн хоёр иргэн өглөөний 08 цаг 30 минутаас эхлэн хүлээсэн гэх бөгөөд 10 цагт ирж байв. Түүнийг ажилдаа ирэх эсэх талаар өрөөнийх нь хүнээс асуухад “дүүрэг дээр ажилтай хэзээ ирэхийг мэдэхгүй” гэж хариулж байлаа. Тэр хоёр хүн бухимдсан байдалтай хүлээсээр байв. Мөн нэмж үйлчлүүлэхээр иргэд ирсээр байсан.

Ярилцлагын үед зарим иргэд хорооны засаг дарга болон ажилчид асуудлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд түргэн шуурхай шийдэж өгдөг, хүндрэл чирэгдэлгүй үйлчлүүлж чаддаг гэж байлаа.

Харин иргэн Б-тэй ярилцахад “Баянзүрх дүүргээс иргэний үнэмлэхээ авахад хаяг нь буруу бичигдсэн байсан. Үүнийг лавлахад хороо оршин суугаа хаягийг чинь буруу бичиж ирүүлснээс алдаа гарсан тул хороондоо хандаж хаягаа засуулаад ир гэсэн. 2012.03.07-нд ирэхэд иргэний бүртгэл хариуцсан ажилтан ямар ч шалтгаан хэлэлгүйгээр нэгдэх өдөр хүрээд ир гээд явуулсан. Би өглөө 8.30 цаг болж байхад ирэхэд нөгөө ажилтан одоо 10 цаг болж байхад ирээгүй түүнийг хүлээж байна гэв.

Дүгнэлт:

- Иргэний үнэмлэх олгох ажлыг хариуцан ажилладаг албан тушаалтнуудын ажилдаа хайнга, хайхрамжгүй хандсанаас болж иргэдийн иргэний

үнэмлэхний овог нэр, хаяг буруу бичигдэх явдал гарсан байна. Үүнээс болж иргэдийг ихээр чирэгдүүлсэн тохиолдол гарсан.

Хорооны тодорхой ажил хариуцсан ажилтнууд нь ажлын байрандаа байхгүй байгаа тохиолдолд хаана, ямар ажлаар явсан болон ирэх хугацаа мэдэгдсэн зар, мэдээллийг байрлуулж ажиллах шаардлагатай байна. Иргэдэд ийм мэдээлэл өгөөгүйгээс тухайн ажилтныг хэзээ ирэхийг мэдэхгүйгээр үүдийг сахин очер дараалал үүсгэх, бухимдал үүсгэх нөхцөл бүрдэж байна.

Хороо нь хэдийгээр шинэ байранд ороод удаагүй байсан ч тухайн барилгын зай багтаамж муутайгаас иргэд үйлчилгээ авах дараалалаа хүлээх хүлээлгийн танхим байхгүй байгаа нь ажиглагдлаа.

Иргэдэд мэдээллийг илүү хүртээмжтэй байдлаар хүргэж байх.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРВАЙХЭЭР, ХАРХОРИН
СУМУУДАД “ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛ”
ШАЛГАЛТ, СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙСЭН ТУХАЙ**

2012.06.04

Улаанбаатар хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу 2012 оны 5 дугаар сарын 29-ны өдөр Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэст, 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Өвөрхангай аймгийн Хархорин сумын нэг цонхны үйлчилгээний цэгт халамжийн үйлчилгээ иргэдэд хүргэхэд нөлөөлж байгаа шаардлагагүй хууль зохицуулалт, хууль тогтоомжоос давсан босго, шалгуурыг бий болгосон дүрэм, журам байгаа эсэх, тогтолцооны доголдол, үйлчилгээний хүртээмжгүй байдал, ажил үүргийн оновчгүй хуваарилалт байгаа эсэх, мэдээллийн ил тод бус, тодорхойгүй байдлын улмаас иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг авах явцад цаг хугацаа алдах, үргүй зардал гаргах, бухимдах зэрэг таагүй нөхцөл байдал үүсэж байгаа эсэхэд ажиглалт хийж, зарим иргэдээс ганцаарчилсан ярилцлага авч ажиллалаа.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэс нь Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Төвийн 2 давхарт үйл ажиллагаагаа явуулдаг. Тус хэлтэс нь хөдөлмөрийн үйлчилгээ үзүүлдэг баг, халамжийн үйлчилгээний баг гэж 2 багт хуваагддаг. Хөдөлмөрийн үйлчилгээ үзүүлдэг баг нь тус байрны 1 давхарт 6 албан хаагч 1 өрөөнд сууж үйлчилгээ үзүүлдэг. Халамжийн үйлчилгээний баг тус байрны 2 давхарт 4 албан хаагч 1 өрөөнд сууж үйлчилгээ үзүүлдэг байна. Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Төвд 2012 оны 5 дугаар сард засвар үйлчилгээ хийгдсэн тул тохь тух, агааржуулалт, гэрэлтүүлгийн хувьд сайн байв. Засвар үйлчилгээ саяхан орсон учир будагны үнэр үнэртэж байв. Хөдөлмөр халамж үйлчилгээний төвийн 1 давхарт иргэдэд зориулсан хүлээлгийн сандал ширээ байрлуулсан байв. Халамжийн үйлчилгээний багийн мэргэжилтэнтэй уулзахад ажлын ачааллын хувьд өдөрт дунджаар 5-10 иргэн ирж үйлчилгээ авдаг гэсэн хариу өгсөн.



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Ажиглалтыг хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн халамжийн багт хийсэн бөгөөд ажиглалтын хугацаанд 1 ахмад настай иргэн тэтгэвэр тэтгэмжийн асуудлаар зөвлөгөө, 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэмжийн талаар зөвлөгөө авсан. Зөвлөгөө авах явцад Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн ажилтан боловсон, соёлтой, асуусан асуултад ямар нэг саадгүй хариулж байсан бөгөөд иргэдэд шаардлагатай мэдээллийг бүрэн дүүрэн өгч хоёр иргэн талархал илэрхийлж явсан болно.

Зөвлөгөө авсан 2 иргэнтэй ганцаарчилсан ярилцлага явуулахад

1. Төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээлэл
 - Оролцогчид ямар төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээ авч байгаа талаар асуухад өндөр настны тэтгэвэр тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн талаар зөвлөгөө авсан.
 - Тухайн халамжийн үйлчилгээ нь ахуй амьдралд нь хэр зэрэг дэмжлэг болж байгаа талаар асуухад нэн шаардлагатай халамжийн үйлчилгээ гэж хариулсан болно.
 - Тухайн халамжийн үйлчилгээг авахад шаардлагатай мэдээллийг хаанаас, ямар арга хэлбэрээр олж авч байгаа талаар асуухад танил, хамаатан садангаасаа асуугаад, хамаатан садан мэдэхгүй бол Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн албан хаагч нараас, халамж үйлчилгээний байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинараас.
 - Төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээний талаар ямар нэмэлт мэдээлэл хэрэгтэй байгаа, түүнийг өөрт чирэгдэлгүй авах арга замын талаар асуухад ерөнхийдөө шаардлагатай мэдээллийг авдаг, 90- ээд оны үед л хүнд суртал, чирэгдэл байсан одоо бол гайгүй болсон учир хэлэх зүйл алга гэсэн хариу өгсөн болно.
2. Халамжийн үйлчилгээнд иргэдийг чирэгдүүлдэг хүнд суртал байгаа эсэх
 - Та бүхэн (та) ямар тохиолдлыг төрийн байгууллага хүнд суртал, чирэгдэл гаргаж байна гэж үзэх вэ? Ийм байдал Та бүхэнтэй тохиолдож байв уу? гэсэн асуултад хүнд суртал гэж өгсөн хүсэлтийг ямар нэг шалтгаангүй удааж хойш нь тавихыг хэлнэ гэж хариулав.
 - Танай орон нутгийн Халамжийн байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй явагддаг бол хэнээс, юунаас болж байна гэж үзэж байгаа тухай, хангалттай гэж үздэг бол үндэслэлийн талаар асуухад сумын хэмжээнд хангалттай гэж үзэж байгаа бөгөөд тэтгэвэр тэтгэмж цаг тухайд нь олгодог, эх орны хишиг тогтмол авдаг хэмээн хариулав.
 - Та энэхүү халамжийн тэтгэвэр эсхүл тэтгэмжийг авахдаа ямар, ямар шат дамжлагыг дамжсан бэ? Таны бодлоор илүү эсхүл дутуу шат дамжлага байсан уу? Тэтгэвэр тэтгэмж авахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлээд л халамжийн ажилтанд очиход яах ёстой заагаад өгдөг гэж хариулж байв.
3. Халамжийн байгууллагын үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр

- Төрөөс ямар бодлого баримталж тусалж дэмжих хэрэгтэй гэж боддог тухай асуухад тэтгэвэр тэтгэмжийн мөнгийг нэмэгдүүлэх хэрэгтэй учир нь зарим хүмүүс тэтгэвэр тэтгэмжээр л амьдардаг бөгөөд энэхүү тэтгэврийн мөнгө тэр бүр хүрэлцдэггүй гэж хариулж байв.
- Та бүхэн ямар тохиолдлыг халамжийн байгууллагын ажилтан өөртэй тань эелдэг боловсон эсхүл үл тоомсорлосон байдлаар харилцаж байна гэж үзэх вэ? гэсэн асуултад халамжийн байгууллагын ажилтан асуусан асуултад зөв хариуг л өгч байвал мөн уурлаж уцаарлахгүй байхыг эелдэг, асуусан асуултад хариулахгүй байхыг үл тоомсорлосон байдал гэж үзэж байна хэмээн хариу өгөв.
- Халамжийн байгууллагаас ямар үйл ажиллагаа зохион байгуулаасай гэж хүсдэг талаар асуухад
- Үйлчлүүлэгч өөрийн зүгээс ямар нэгэн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах боломжтой эсэх талаар асуухад боломжтой, мэдээллээр өгч хамтран ажиллах боломжтой гэж хариулснаар ганцаарчилсан ярилцлагыг өндөрлөв.

Мэдээллийн ил тод байдлын хувьд иргэдийг ресепшн хүлээн авч иргэдэд хэрэгтэй мэдээллийг өгч шаардлагатай тохиолдолд холбогдох албан хаагчтай уулзуулахаар чиглүүлж өгдөг. Мөн иргэдэд шаардлагатай мэдээ, мэдээлэл 1 давхрын 2 төрлийн ханын самбарт байрлаж байв. Гэсэн хэдий ч 1 давхрын ханын самбарт ямар нэг үйлчилгээ авахад бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтын жагсаалт байхгүй байсан бөгөөд энэ тухай тодруулж асуухад ресепшн эсвэл холбогдох албан тушаалтнаас бүрдүүлэх бичиг баримтыг жагсаалтыг авдаг гэсэн хариу өгсөн. Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн цахим хуудаст мэдээ мэдээлэл оруулж, засвар хийгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар ашиглалтад ороогүй байна.



Өвөрхангай аймгийн Хархорин сумын нэг цонхны үйлчилгээ нь тус сумын Засаг даргын тамгын газрын 2 давхарт байрладаг. Нэг цонхны үйлчилгээ нь 2009 оноос иргэдэд үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд засвар үйлчилгээний хувьд сайн. Байрны тохь тух, агааржуулалт, гэрэлтүүлгийн хувьд сайн, ямар нэг дутагдал байхгүй байв. Хөдөлмөр халамжийн үйлчилгээг нэг албан хаагч иргэдэд хүргэдэг

бөгөөд бусад сумуудаас иргэд ирж халамжийн үйлчилгээ авдаг байна. Нэг цонхны үйлчилгээ үзүүлдэг өрөөнд сандал байрлуулсан бөгөөд 6 төрлийн өөр үйлчилгээ үзүүлдэг цонх нэг өрөөнд байдаг учраас дуу чимээ ихтэй, иргэд олноор цугларсан байв. Ажиглалтын явцад нэг ахмад настан эх орны хишиг болох 21000 төгрөг орсон эсэх талаар лавлагаа авсан. Иргэн ганцаарчилсан ярилцлага өгөх боломжгүй гэсэн хариу өгсөн.



Мэдээллийн ил тод байдлын хувьд иргэдэд шаардлагатай мэдээлэл халамж үйлчилгээний цонхонд хадаастай байв. Мөн ямар нэг үйлчилгээ авахад бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, хандах этгээд, ямар бичиг баримт биедээ авч очих талаарх мэдээллийг хавтасанд хийж цонхны урд тавьсан байв. Ажиллах цагийн хувиар байхгүй байв.



Ажиглалтаар боловсруулсан мэдээлэл болон ганцаарчилсан ярилцлагын үндсэн дээр дараах дүгнэлтийг урьдчилсан байдлаар гаргав. Үүнд:

- Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин сумуудын нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх ажлын ачаалал харилцан адилгүй байна. Иймд халамжийн үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагын орон тоог

тухайн орон нутагт нийгмийн халамжийн үйлчилгээ авах хүн амын тоог харгалзан тогтоох шаардлагатай нь харагдлаа.

Ажиглалтын явцад үзүүлсэн үйлчилгээнээс үзэхэд иргэд мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа их авдаг байна.

Ажиглалтаас үзэхэд төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамжийн үйлчилгээ нь иргэдэд хүрч байгаа, иргэдийн сэтгэл ханамжийг нааштайгаар үнэлж болохоор байна.

Халамж үйлчилгээ авч буй байрны нөхцөл байдлаас үзэхэд иргэдэд үйлчлэхэд боломжийн ая тухыг хангасан байдалтай байна.

“Хүний эрх ба хүнд суртал чирэгдэл” судалгааны танилцуулга

2012.08.30

Улаанбаатар хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга 2012 оны 2 дугаар сарын 9-ний өдөр “Хүний эрх ба хүнд суртал чирэгдэл” судалгааны ажлыг зохион байгуулах удирдамж баталсан билээ.

Судалгаа нь төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхэд учирч буй хүнд суртал, чирэгдлийн шалтгаан нөхцөл, үр дагавар, хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, арилгах арга замын талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой болно.

Комиссоос зарласан сонгон шалгаруултад тэнцсэн “Карьер хөгжлийн хүрээлэн”-гийн судалгааны баг “Хүний эрх ба хүнд суртал- нийгмийн халамжийн салбар дах төрийн үйлчилгээ” судалгааг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа газрууд болох Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, нийслэлийн Сүхбаатар, Сонгино хайрхан, Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Сүхбаатар дүүргийн 2, Сонгино хайрхан дүүргийн 1, Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороодыг хамруулан зохион байгуулсан байна.

Судалгааны ажлын зорилгыг хангах үүднээс дараах үндсэн 4 зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлжээ. Үүнд:

Зорилт 1. Халамжийн салбарт үйлчилж буй эрх зүйн баримт бичгүүдэд шинжилгээ хийх замаар төрөөс үзүүлж буй халамжийн үйлчилгээний хүрээнд шаардлагагүй зохицуулалт, босго, шалгуур байгаа эсэхийг тодруулж, Нийгмийн халамжийн шинэ хуульд нийцүүлэн гаргах дүрэм журмуудад тусгах санал боловсруулах;

Зорилт 2. Сонгогдсон төрийн байгууллагууд дээр ажиглалтын судалгаа явуулж, үйл ажиллагааны доголдол, давхардал, шаардлагагүй шат дамжлага, ажил үүргийн оновчгүй хуваарилалт байгаа эсэхийг тодруулах, мэдээллийн ил тод байдалд шинжилгээ хийх;

Зорилт 3. Иргэд, төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдийн санаа бодлыг тандах, ярилцлага хийх, баримт цуглуулах, тохиолдол судлах замаар халамжийн салбар дахь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд хүндрэл бэрхшээл, хүнд суртал, чирэгдэл байгаа эсэхийг тодруулах;

Зорилт 4. Төрөөс иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээнд оршиж буй хүндрэл бэрхшээл, хүнд суртал, чирэгдлийг арилгах арга замыг тодорхойлж, түүнийг сайжруулах санал бүхий зөвлөмж боловсруулах;

САНАЛЗӨВЛӨМЖ

а) Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр

Төрөөс иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлтэй болгож буй гол шалтгаан нь “үйлчилгээ авах хугацаа”, “бүрдүүлэх баримт бичиг”, “төрийн албан хаагчдын зан харилцаа”, “үйлчилгээний стандарт”- тай холбоотой байгааг бид өмнө тэмдэглэсэн билээ. Мөн хууль тогтоомжийн хийдэл нь хүнд суртлын нэг шалтгаан болж байна. Иймээс дурдсан асуудалтай холбоотойгоор дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар доорх санал, зөвлөмжийг өгөх нь зүйтэй байна.

Иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг авахад зарцуулах хугацаа болон бүрдүүлэх баримт бичгийг журамласан байдал нь тодорхой байх шаардлагатай байна. Үүнд:

- Хөдөлмөрийн чадвар алдсанаас тусламж, үйлчилгээ авах нийт хугацаа: Энэ талаар Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүрэмд “хөдөлмөрийн чадвар алдсан байдалд байгаа хугацааг эхний удаад 3-24 сараар, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан бол 3-12 сараар тус тус тогтооно (3.4) гэж заасан нь амьдралд нийцэхгүй байгааг эргэн харах хэрэгтэй байна.
- Иймд тухайн үйлчилгээг үзүүлэхэд төрийн байгууллагын зүгээс зарцуулах нийт болон хэсэгчилсэн хугацааг үе шат болгоноор тооцож, холбогдох дүрэм, журамд тусгах нь төрийн үйлчилгээний хүнд суртал чирэгдлийг багасгах, хянах нэг үзүүлэлт болохоор байна.
- Холбогдох шийдвэрийг гаргах хугацаа: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам, Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүрэмд зааснаас үзэхэд Амьжиргааг дэмжих зөвлөлийн, мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрүүд гарах хугацаа бүрхэг, тодорхойгүй байгааг нарийвчлан журамлах шаардлагатай¹.
- Бүрдүүлэх баримт бичгийн тухайд тэдгээрийн олон, цөөнөөс гадна, түүнийг бүрдүүлэхэд зарцуулж буй хугацаа, шат дамжлага, үндсэн болон нэмэлт бүрдүүлэх баримт бичигтэй холбоотой асуудал үүсдэг байна.
- Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр нь нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс бусад иргэдийг халамжийн үйлчилгээнд хамруулах эсэх асуудлыг шийддэг.² Иймээс халамжийн үйлчилгээнд хамрагдах бусад бүх иргэнд хуульд зааснаар Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар орж протокол хавсаргасан байх гэсэн шаардлага тавьдаг нь иргэдийг чирэгдүүлдэг нэг нөхцөл болдог байна. Иймээс тухайлбал, ахмад настан, түүний дотор өндөр настнуудад үзүүлэх халамжийн үйлчилгээнд уг зөвлөлийн шийдвэр гаардлагагүй байж болно.

¹ Тухайлбал, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэмд долоо хоногт нэг удаа хуралдах (5.2), 30 хоногт гомдлыг шийдвэрлэхээр (5.5) журамласан байна. Нийгмийн халамжийн тухай хууль. 27.1

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн аливаа тусламж, дэмжлэгийг авахад бүрдүүлэх үндсэн баримт бичиг нь “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэний үнэмлэх” байна. Уг үнэмлэхийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн олгодог бөгөөд хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болох тухай хуульд заасан байна. Иймээс Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журмын холбогдох заалтыг тухайлан уг хоёр баримт бичгийг хоёуланг нь шаардаж буй заалтуудыг өөрчлөх боломжтой байна.

Төрийн байгууллагын ажилтны харилцаа, үйлчилгээний стандарттай холбогдож үүсэж буй хүнд суртал чирэгдлийг шийдвэрлэхийн тулд холбогдох дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгож, шинээр нэмж боловсруулж мөрдөх шаардлагатай.

Нөгөө талаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах явдал шинээр боловсруулахаас ч илүү анхаарал татаж байна. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмээс эхлээд нийгмийн халамжийн тухай хууль, байгууллагын дотоод журам, бусад актуудад ажилтан албан хаагчдын тухайлбал, нийгмийн ажилтны үүрэг хариуцлагын (Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйл) хүрээнд ёс зүйн шаардлагыг тусгасан байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болохоор байна. Энэ нь төрийн албан хаагчдын харилцаагаар тухайлбал, иргэдийн хувийн нууцыг санаатай, санамсаргүйгээр задлах, хүний эрхэм зэргийг үл хүндэтгэх зэргээр илэрч байна. Нийгмийн халамжийн салбарын ажилтнуудын энэ байдал нь тэдний хүний эрхийн боловсрол, иргэнд үйлчлэх харилцаа, хандлагатай холбоотой гэж үзэх үндэстэй юм.

Хууль тогтоомж нь эрх зүйн хийдэлтэй, зохицуулах ёстой харилцааг бүрэн зохицуулаагүй буюу журамлаагүй байдал нь төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлтэй болгож буй нэг нөхцөл болж байна хэмээн үзэж энэ чиглэлээр дараах зөвлөмжийг өгөх нь зүйтэй гэж судалгааны баг үзлээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хуулийн “асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн”-д халамж үзүүлэх тухай заалт нь зарим иргэдийн хувьд тухайлбал, үр хүүхэдтэй ч тэд нь хайхардаггүй, ганц өргөмөл хүүхэдтэй ч тэр нь асран хамгаалдаггүй гэх мэт тохиолдолд хууль ёсны эрхээ эдэлж чадахгүй байдалд хүргэж байгааг анхааралдаа авч холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох, шаардлагатай тохиолдолд хуулийн тайлбар гаргуулах хэрэгцээ байна.
- Ахмад настнууд таяг, тэргэнцэр авахын тулд хуулийн заалтад нийцүүлж заавал эмнэлгийн дүгнэлт гаргуулах, ямар нэгэн өвчтэй гэсэн онош тогтоолгон хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоонд орох шаардлага гарч буй байдалд дүгнэлт хийж, Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журамд холбогдох өөрчлөлт оруулах, асран хамгаалагчаа сонгоход заавал нэг хаяг дээр байх ёстой гэх мэт хуулиас давсан зохицуулалт шаардаж буй нэгж байгууллагын дүрэм, журмыг өөрчлөх шаардлагатай.

- Судалгааны баримт болон дүгнэлтээс үзэхэд эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комисс, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааг нарийвчлан журамлах хэрэгцээ байна. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм нь зөвхөн нийгмийн даатгалд хамрагдсан иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой харилцаанд оролцогчдын зан үйлийг журамлахад чиглэгдсэн байдгаас нийгмийн халамжийн үйлчилгээнд оролцогчдын зан үйлийг орхигдуулсан байх талтайг нарийвчлан судалж, нийгмийн халамжийн тухай болон нийшмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх дүрэм, журмыг уялдаа холбоонд нь авч үзэх нь нэн чухал байна.

Б) Үйлчилгээний стандарттай холбоотой асуудлаар

Халамжийн ажилтны эмзэг бүлгийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудтай харилцдаг онцлогыг харгалзан тусгай стандарт боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Стандартыг боловсруулахдаа дараах зарчмыг мөрддөг болохыг мэргэжилтнүүд зөвлөж байгааг анхаарахыг санал болгож байна. Үүнд³:

- Нэгэн утгатай хэрэглэх нөхцлийг хангах нь стандартын нэг зарчим юм. Хууль тогтоомжид иш татагдсан стандарт заавал мөрдөгдөх учиртай бөгөөд ялангуяа, Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн хуульд төрөлжсөн асрамжийн үйлчилгээний болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, шаардлагыг боловсруулан хэрэгжүүлэхийг асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн болон стандартчиллын байгууллагад үүрэг болгосон байна.
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсруулагч, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн сонирхлыг тэнцвэржүүлэх. Энэхүү зарчим нь нийгмийн халамжийн үйлчилгээг авахтай холбогдож үүсэж буй харилцаанд оролцогч сонирхлын бүлгүүдийн хуулиар баталгаажсан сонирхлыг дээд зэргээр харгалзан үзэхэд оршино. Наад зах нь нийгмийн халамжийн үйлчилгээг авч буй иргэд, төрийг төлөөлөн ажиллаж буй мэргэжлийн бүлгүүд хэлэлцэж байгаа гол асуудлаар санал нэгдэж ерөнхий зөвшилцөлд хүрсэн байна гэсэн үг юм.
- Стандартчиллын түрүүлэх хөгжлийг хангах. Шинээр боловсруулж буй стандарт нийгмийн хөгжлөөс түрүүлэх хандлагатай байх ёстой. Түрүүлэх хандлага стандартад шинэ дэвшилтэт технологи, сорилт туршилтын арга, чанарын үзүүлэлт, шаардлагыг тогтоох боломж олгоно.
- Стандартын агуулгыг тодорхой томъёолох. Хоёрдмол утгатай хэм хэмжээ норматив баримт бичгийн ноцтой дутагдлыг харуулдаг. Иймд стандартыг нэг утгатай товч, тодорхой агуулгатайгаар боловсруулна.
- Үзүүлэлт, шаардлагыг шалгах, хэмжих бодит байдал. Стандарт нь харилцан орлуулалт, нийцтэй байдал, хүрээлэн буй орчин, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж байгаа шаардлагыг оролцуулаад бодитой шалгагдах, стандартчиллын объектын үндсэн шаардлагуудыг тогтоох ёстой.

³ Т.Сосорбарам., “Европын стандартыг монголд нутагшуулах асуудал” УБ., 2011

- Стандартыг нэг хэлбэрээр хэрэглэх нөхцлийг хангах. Энэхүү зарчмыг байгууллагын стандарт боловсруулахад харгалзан үздэг. Байгууллагын стандартыг боловсруулах, батлах, бүртгэх, хүчингүй болгох, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах журмыг өөрсдөө бие дааж тогтоож хэрэгжүүлнэ. Ингэхдээ холбогдох, хууль тогтоомж, улсын стандартыг мөрдлөг болгож түүний шаардлагуудад харшлахгүй харин ханган биелүүлэхэд чиглэсэн стандартчиллын нийтлэг зарчмын дагуу нэгдсэн хэлбэр, бүтэц, агуулгатай байна.

с) Халамжийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр

- Халамжийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгоход эн тэргүүнд анхан шатны үйлчилгээ үзүүлж буй хороонд зарчмын өөрчлөлт хийх шаардлагатай байна. Шинэчилсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт “Сум, хорооны нийгмийн ажилтны орон тооны жишиг, нормативыг тухайн засаг захиргааны нэгжийн хүн ам, нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоог харгалзан нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн заалтыг нэн даруй хэрэгжүүлэх, тооцоо судалгааг бодитой гаргах шаардлагатай.
- Шинэчлэн баталсан хуулиар Нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн бүлэг нэмэгдсэн тул энэ төрлийн үйлчилгээг хүргэх алба, ажилтны орон тоо байх шаардлагатай. Тухайлбал: боловсролыг дэмжих, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ г.м
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдан гарахтай холбогдож хороо, дүүрэг, нийслэлийн халамжийн байгууллагын бүтэц, орон тоонд хэрхэн өөрчлөлт оруулах асуудлыг ч одооноос судалж бодитой санал бэлтгэх шаардлагатай байна.
- Халамжийн байгууллагын бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор ажиллах цагийн хуваарь, иргэдэд үйлчилдэг өдрийн хуваарийг эргэн харах, халамжийн ажилтныг орлон гүйцэтгэх боломжтой байхаар зохицуулалт хийх нь зүйтэй байна.
- Хорооны халамжийн ажилтнуудын ажлын хэрэгцээнд шаардлагатай програм хангамжийг суурилуулж, дүүргийн халамжийн байгууллага, мэдээллийн санд шууд холбогдох боломжийг нээж өгөх, ингэснээр иргэдийг чирэгдүүлэхгүй байх, шат дамжлага цөөрөх нэг нөхцөл бүрдэх боломжтой.

с!) Мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр

Халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг иргэнд хүртээмжтэй ил тод болгож өөрчилөхгүйгээр үйлчилгээг иргэнд ойртуулах боломжгүй юм. Мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Дүүргүүдийн халамжийн байгууллагууд өөрийн цахим хуудастай болох, холбогдох бусад цахим хуудсуудын мэдээллийн агуулгад шинэчлэлт хийх, Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу халамжийн байгууллагууд цахим хуудас болон мэдээллийн самбартай дараахь мэдээллийг тогтмол байршуулж, шинэчилж байх. Үүнд

- o Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн o Албан хаагчийн ёс зүйн дүрэм
- o Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь o Үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт o Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар o Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх
- Иргэнд хүргэж буй мэдээлэл, гарын авлага, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллүүдийг цаг тухайд нь шинэчилж байх
- Төрийн үйлчилгээ, тэр дундаа халамжийн үйлчилгээний талаар хэвлэл мэдээллээр өгч байгаа мэдээллийг сонирхолтой, реклам байдлаар иргэдэд ойлгомжтой хэлбэрээр өгөх

е) Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр

- Халамжийн байгууллагын Төрийн албан хаагчдын цалин хангамжийг нэмэгдүүлэх, ажлын нөхцөлд үнэлгээ хийж, тодорхойлох
- Хорооны халамжийн ажилтнуудын ажлын хэрэгцээнд шаардлагатай програм хангамжийг суурилуулж, дүүргийн халамжийн байгууллага, мэдээллийн сандаа шууд холбогдох боломжийг нээж өгөх,
- Халамжийн ажилтнуудыг нийгмийн ажил мэргэжлийн болон харилцаа, сэтгэл судлал, тусгай хэрэгцээт боловсрол г.м чиглэлээр сургалтуудад үе шаттай хамруулах
- Халамжийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримтлах, дадлагжуулж, мэргэшүүлэх хүний нөөцийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх
- Халамжийн ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх замаар тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

Г¹) Халамжийн үйлчилгээ үзүүлэхэд учирч болох хүнд сурталыг багасгах талаар авах арга хэмжээний талаар

“Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зарим арга хэмжээний тухай 2010 оны 3 дугаар сарын 24-ний 68 дугаар тогтоол”-ыг эс тооцвол хүнд суртал чирэгдэл гэсэн нэр томъёогоор иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд учирч буй чирэгдлийг арилгах талаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас гаргасан зөвлөмж, мэдээ судалгаа байхгүй байна. Харин Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй дүрэм, журам иргэдэд хүнд суртал, чирэгдэл учруулж буй эсэхийг хянан үзэж хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм, журмыг хүчингүй болгуулах талаар санал боловсруулах, ажлыг аймаг, орон нутагт зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд хүнд суртал, чирэгдлийн асуудлаар үүсэж болох нөхцөл байдлууд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх бодлогын чиглэлтэй цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал байна. Үүнд:

- Хүнд суртал, чирэгдэл үүсгэж болох нөхцөл байдлуудыг судлан ажилтнуудын зан харилцаа, үйлчилгээний чанар хүртээмж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, хүлээлтийн асуудлаар тогтмол судалгаа авч байх;
- Халамжийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгох
- Мэргэжлийн ёс зүйн дүрмүүдийг эргэж харах;
- Нийгмийн болон халамжийн ажилтнуудыг “нийгмийн ажил”-аар мэргэшүүлэх, сертификат олгох;
- Халамжийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд харилцаа хандлагын ур чадвар хэсэгт энэ асуудлыг суулгаж өгөх;
- Хүний эрх, ёс зүй, харилцааны сэтгэл зүй, нийгмийн ажилтны мэргэжлийн сургалтуудад халамжийн ажилтнуудыг үе шаттай хамруулах;
- Халамжийн ажилтнуудын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан Хүний эрх зөрчигдөж болох нөхцлүүдийг нийгмийн болон халамжийн ажилтнууд бүртгэж, судалгаатай ажиллах, халамжид хамрагдсан биш хамрагдаж чадахгүй байгаа иргэдийн амьдралын нөхцлийг судлах, тэдэнд чиглэсэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлдэг байх талаар халамжийн байгууллагууд шат шатандаа оновчтой арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй.

е) Хүний Эрхийн Үндэсний комиссын зүгээс цаашид авч хэрэгжүүлэх хяналт шалгалт, зөвлөмж, сурталчилгаа, мэдээллийн ажилд анхаарах асуудлаар

- Хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах ыүзэх эрхийнхээ хүрээнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журмуудад гол анхаарлаа чиглүүлэх;
- Ингэхдээ хууль, дүрэм, журмын тодорхой нэг заалтын хэрэгжилтэд шинжилгээ хийх замаар ерөнхий биш тодорхой асуудлыг хөндөж, дүгнэлт гаргахад анхаарах;
- Хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах зорилтыг хэрэгжүүлэхдээ гэр бүл дэх хүүхдийн эрхийн зөрчлийн асуудалд гол анхаарлаа чиглүүлж⁴, эцэг эхийн хүний эрхийн боловсрол дутмаг байдлаас санаатай болон санамсаргүй байдлаар хүүхдийн эрх хөндөгдөж

⁴ Сургууль, боловсролын байгууллагуудад энэ асуудал тодорхой ахицтай байгаа боловч гэр бүл дэх асуудал орхигдож байгааг судлаачид тэмдэглэж байна.

буй байдалд судалгаа хийж, эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж боловсруулах, залуу эцэг эхчүүдийн хүний эрхийн боловсролд чиглэсэн сургалт судалгаа, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

- Ажлын байран дахь хүчирхийлэл, хүнд суртал, чирэгдэл, хүний эрхийн зөрчлийн асуудлыг төрийн болон хувийн хэвшлийн томоохон байгууллагаар хязгаарлалгүй, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид рүү чиглүүлэх; (уул, уурхай, ил задгай газар худалдаа эрхлэгчид, нийтийн тээврийн хэрэгсэл, микро автобус, хот хоорондын тээвэр гэх мэт)
- Хүний эрх зөрчиж байгаа талаарх мэдээлэлд тодорхой судалгаа дүгнэлттэй хандах, шалгалт болон судалгааны шинжилгээний ажилд ялгаатай байр сууринаас хандаж арга зүйг боловсруулахад анхаарах;
- Хүний Эрхийн Үндэсний комиссын дэргэд сургалт судалгааны мэргэшсэн баг байгуулах;
- Хүний Эрхийн сургалт, судалгааны болон энэ чиглэлийн Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах замаар Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд нэгтгэн зохион байгуулах чиг үүргийг Комисст төвлөрүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх;

UIN.MN
СУДАЛГААНЫ САН